БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭРГЭДЭХ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ
"ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ"

№	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт		Авбал зохих оноо	Оноо[1]	Хувийн жин[2]
1	2	3		4	5	6
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3] (ҮХХ)	Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн батлагдсан эсэх[4]		1	0	0
2		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх [5]		1	1	10
3		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал	Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх [6]	0,5	0.5	5
			Соён, гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал[7]	0,5	0.5	5
			Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал[8]	0,5	0	0
			Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал[9]	0,5	0.5	5
Хэсгийн оноо				**4**	**2.5**	**25**
4	Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал (ЁЗМ)	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх [10] (*зарсан дүгнэлтийн хувийн жинээр тооцох бөгөөд бүтэн оноо*)		1	1	10
5		Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал[11]		1	1	10
6		Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал[12]		1	1	10
Хэсгийн оноо				**3**	**3**	**30**
7	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа (ЁЗДХ)	Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал[13]		1	1	10
8		Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал [14] (*Гомдол ирээгүй бол 1 оноо авна, нийт ирүүлсэн өргөдөл, гомдлын хувийн жинээр тооцно*)		1	1	10
9		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж, тайлагнасан байдал [15]		1	1	10
Хэсгийн оноо				**3**	**3**	**30**
Үнэлгээний нийт оноо, хувь				**10**	**8.5**	**85**

$$\text{Эзлэх хувь} = \frac{\text{ҮХХ} + \text{ЁЗМ} + \text{ЁЗДХ}}{10} * 100\%$$

Тайлбар:

[1] Байгууллагын өөрийн болон харьяа, салбар байгууллагад өгсөн үнэлгээ.

[2] Авсан оноог 10-аар үржиж хувийн жинг тооцох ба нийт дүн 100-с хэтрэхгүй байна.

[3] УИХ-ын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр".

[4] ЁЗХ-ны 2025 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан "Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт"-д нийцүүлэн батлагдсан төлөвлөгөөг хавсарган ирүүлнэ.

[5] ЁЗХ-ны 2025 оны 06 дугаар "Аргачлал батлах тухай" тогтоол.

[6] УИХ-ын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн 2.1 дэх хэсэг, ЁЗХ-ны 2024 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын 4.1.3, мөн оны 15 дугаар "Сургалтын агуулга, сэдэв батлах тухай" тогтоол.

[7] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалт.

[8] ЁЗХ-ны 2025 оны 06 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээний аргачлал"-ын 8.3.3, мөн оны 07 дугаар "Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргах, шалган шийдвэрлэх талаар авах арга хэмжээний тухай" тогтоол.

[9]ЁЗХ-ны 2024 оны 13 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам"-ын 3.8 дахь хэсэг, 2025 оны 08 дугаар "Загвар батлах тухай" тогтоол.

[10] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалт.

[11] Мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг.

[12] Мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалт.

[13] ЁЗХ-ны 2024 оны 13 тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам"-ын 4.2.2 дахь заалт.

[14] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.1 дэх заалт.

[15] ЁЗХ-ны 2024 оны 13 тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам"-ын 4.4.3, 4.4.4 дэх заалт.

-oOo-

БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭРГЭДЭХ
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ
ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН
“ТАЙЛАНГИЙН МАЯГТ”[1]

НЭГ. Товч танилцуулга[2]
Боловсролын ерөнхий газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороонд харьяалагдах 62 байгууллагаас 50 байгууллага буюу 80,6 хувь нь ёс зүйн дэд хороог байгуулан ажиллаж байна. Ёс зүйн дэд хороог байгуулаагүй 12 байгууллага нь 10 болон түүнээс доош орон тоотой байгууллага байгаа тул харьяалах дээд шатны байгууллага болох Боловсролын ерөнхий газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороонд гомдол, мэдээллийг гарган шийдвэрлүүлж байна. Боловсролын ерөнхий газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороо болон харьяа байгууллагын хэмжээнд нийт 16 гомдол, мэдээлэл ирж, хяналт шалгалтыг хууль тогтоомжийн дагуу явуулж, холбогдох дүгнэлтийг гарган ажиллаж байна. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3 болон 8.1.4 дэх хэсэгт холбогдох ёс зүйн нийтлэг шаардлагыг зөрчсөн гомдол, мэдээллийг Ёс зүйн дэд хороонд төрийн албан хаагчаас ихэвчлэн гаргаж байна.
ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар
2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3]:
“Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн Зорилт 1.1 “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг бууруулах замаар зөрчлөөс урьдчилан сэргийлнэ” арга хэмжээний хүрээнд “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээний аргачлалын дагуу байгууллагын нийт албан хаагчдыг ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээнд хамруулсан. Үнэлгээг хийхдээ тоон аргыг ашиглан, байгууллагын 113 албан хаагчаас удирдах 11 албан тушаалтан, гүйцэтгэх 102 албан тушаалтнуудыг оролцуулсан. Үүнээс төрийн албан хаагч төрийн чиг үүргийн хүрээнд ажиллахад тулгамдаж буй асуудал, бэрхшээлийг тодорхойлох хэсэгт 1-5 оноотой 70 албан хаагч, 6-10 оноотой 37 албан хаагч, 11-15 оноотой 5 албан хаагч, 16-25 оноотой 1 албан хаагч байна. Харин байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалт, соёлын тухайд тохиолдож буй бэрхшээлийг тодорхойлох хэсэгт 1-5 оноотой 102 албан хаагч, 6-10 оноотой 10 албан хаагч, 16-25 оноотой 1 албан хаагч байна. Боловсролын ерөнхий газрын нийт албан хаагчдын эрсдлийн хүрээ бүр дэх эрсдэлийн дундаж түвшин 4 оноотойгоор үнэлэгдэж, IV түвшинд эрэмбэлэгдэж, бага эрсдэлтэй зэрэглэлд багтаж байна. Иймд хяналтыг үргэлжлүүлж, шууд арга хэмжээ авах шаардлага үүсээгүй болно.
2.2.Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:
Боловсролын ерөнхий газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороо болон харьяа байгууллагын ёс зүйн дэд хороонд ирсэн нийт 16 гомдол, мэдээлэлд хяналт шалгалтыг явуулж, үүнээс ёс зүйн дэд хороо 13 дүгнэлтийг гаргаж, томилох эрх бүхий албан тушаалтанд дүгнэлтийг хүргүүлсэн. Үүнээс 9 “Ёс зүйн зөрчил гаргасан тухай”, 4 “Ёс зүйн зөрчил гаргаагүй тухай” дүгнэлт байна.

[1] Маягтын дагуу тайланг 5 хуудаснаас ихгүй, товч үр дүнг нэгтгэн ирүүлнэ.

[2] Байгууллагын харьяа салбар, нэгжийн хэмжээнд Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх байдлын талаар товч мэдээллийг тайлагнана.

[3] Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагааны талаар тайлагнана.

Тухайн томилох эрх бүхий албан тушаалтнууд дүгнэлтийг үндэслэн нийт 9 албан хаагчид холбогдох хуулийн дагуу хариуцлага ногдуулах шийдвэрийг гарган ажиллаж байна.
2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:
Боловсролын ерөнхий газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороонд харьяалагдах 62 байгууллагаас 50 байгууллага ёс зүйн дэд хороог байгуулан ажиллаж байна. Ёс зүйн дэд хороог байгуулаагүй 12 байгууллага нь 10 болон түүнээс доош орон тоотой байгууллага байгаа тул харьяалах дээд шатны байгууллага болох Боловсролын ерөнхий газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороонд гомдол, мэдээллийг гарган шийдвэрлүүлж байна. Боловсролын ерөнхий газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороонд харьяа байгууллагын 38 байгууллагаас ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны тайланг ирүүлсэн бөгөөд тус дэд хороод үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан баталж, 2 болон түүнээс дээш удаа “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай” хууль тогтоомжийн дагуу нийт давхардсан тоогоор 46 удаагийн сургалтаар 4210 хүнд зохион байгуулсан байна. Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүрээнд нийт ёс зүйн дэд хороод 10 удаагийн нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, байгууллагын албан хаагчдын ёс зүйн тухай мэдлэг, боловсролыг дээшлүүлэн ажиллаж байна.

Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл:
Төрийн албан хаагчийн ёс зүйн гомдол, мэдээллийг хянан шалгаж, ёс зүйн зөрчилд хариуцлага хүлээлгэдэг болсноороо төрийн албан хаагчдын ёс зүйн сахилга батыг нэмэгдүүлэх гол нөлөөллүүдийг нэг болж байна.	Харьяа 21 аймагт байрлах Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага, Насан туршийн суралцахуйн төвүүдээс гаргаж буй гомдол, мэдээллийн дагуу нотлох баримтыг цуглуулж, хянан шалгахад бэрхшээл тулгарч байна. Тухайлбал, 1. Ёс зүйн дэд хорооны хуралдааныг заавал цахим хэлбэрээр зохион байгуулах хэрэгцээ шаардлага үүсэж байна. 2. Нотлох баримттай танилцахад тухайн оролцогчид биеэр ирж танилцах уу, цахим хэлбэрээр танилцах уу гэдэг нь ойлгомжгүй. 3. Нотлох баримтыг хуулбарлаж, цахимаар танилцуулахад ёс зүйн зөрчилд холбогдогч этгээд нь гомдол гаргагчийг дарамтлах 4. Ёс зүйн дэд хорооны гишүүдэд урамшуулал дэмжлэг үзүүлэхгүй ажлын ачаалал нэмэгдсэнээс хамаарч ажиллах сонирхолгүй болох 5. Ёс зүйн зөрчил нь ихэвчлэн ёс суртахуун харилцааны шинжтэй байдаг тул нотлох баримт цуглуулах, бодитой дүгнэлт гаргахад бэрхшээлтэй 6. зэрэг асуудлууд маш ихээр гарч байна. Мөн томилох эрх бүхий этгээдээс ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэж хариуцлага хүлээлгэж байгаа ч хэрхэн хариуцлагыг хүлээлгэх нь асуудалтай байна. Учир нь тус байгууллагын харьяа байгууллага нь ихэвчлэн хөдөө, орон

	нутагт байрлаж үйл ажиллагаа явуулдаг тул хариуцлагыг биелүүлсэн эсэхийг шалгахын тулд заавал томилолтоор явах хэрэгцээ үүсдэг зэрэг нь бэрхшээл үүсгэж байна.
Санал:	
1. Бүтэц, орон тооны хувьд 10-аас доош албан хаагчтай байгууллагад ёс зүйн дэд хороо ажиллах хүндрэлтэй тул харьяалах дээд шатны Ёс зүйн дэд хороондоо гомдол, мэдээллийг гаргаж, шийдвэрлүүлэх; 2. Оролцогчид нотлох баримттай танилцах эрхийг илүү нарийвчилсан байдлаар оруулж өгөх; 3. Шинэ тутам байгуулагдаж байгаа ёс зүйн дэд хороотой байгууллагуудын дэд хорооны гишүүдийг байгуулагдсан жилийг харгалзан үе шаттай сургалтанд хамруулах; 4. Ёс зүйн дэд хороонд ажиллаж буй албан хаагчдын урамшууллыг байгууллагын төсөвт суулгах асуудлыг шийдвэрлэх.	

Шалгах хэсэг:

- ☐ “Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт”-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.
- ☐ Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.
- ☐ Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Боловсролын ерөнхий газрын дарга:

_____ _____ /Т.Ням-Очир/

/Албан тушаал/ */Гарын үсэг/* */Гарын үсгийн тайлал/*

Ёс зүйн дэд хорооны дарга:

_____ _____ /Б.Лхагвабаяр/

/Албан тушаал/ */Гарын үсэг/* */Гарын үсгийн тайлал/*

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга:

_____ _____ /Б.Цэнгүүн/

/Албан тушаал/ */Гарын үсэг/* */Гарын үсгийн тайлал/*

Огноо: 2026 оны 01 сарын 08

БАТЛАВ:
БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДЭРГЭДЭХ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
ДАРГА Б.ЛХАГВАБАЯР

БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭРГЭДЭХ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2025.01.30

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хүрэх түвшин	Хариуцах албан хаагч
1	Ёс зүйн дэд хорооны 2024 оны үйл ажиллагааны тайланг Ёс зүйн хороонд хүргүүлэх		Ёс зүйн дэд хорооны 2024 оны үйл ажиллагааны тайланг Ёс зүйн хороонд хүргүүлсэн байна.	Ёс зүйн дэд хороо
2	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөө баталж, хэрэгжилтийг хангах	I-IV дүгээр улирал	2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө батлагдсан байна.	
3	Албан хаагчдад ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зөвлөгөө мэдээлэл өгөх	I-IV дүгээр улирал	Тухай бүр зөвлөгөө мэдээлэл өгсөн байна.	
4	Төрийн албан хаагчийн ёс зүйн сахилга, хариуцлагыг дээшлүүлэх, ёс зүйн мэдлэгт дэмжлэг үзүүлэх сургалт зохион байгуулах	III-IV дүгээр улирал	Албан хаагчдийн ёс зүйн мэдлэг дээшилсэн байна.	
5	Албан хаагчдын ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдлыг хянан шийдвэрлэх	Тухай бүр	Ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдлыг 100 хувь шийдвэрлэсэн байна.	

Ёс зүйн хорооны 2025 оны ... дүгээр
сарын ...-ний өдрийн ... дугаар тогтоолын
гуравдугаар хавсралт

БАГАНУУР ДҮҮРГИЙН НАСАН ТУРШИЙН СУРАЛЦАХУЙН ТӨВИЙН 2025 ОНЫ
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

НЭГ. Товч танилцуулга[1]

Багануур дүүргийн Насан Туршийн Суралцахуйн Төв нь анх 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдөр тус төвийн захирлын А / 42 тоот тушаалаар Ёс зүйн зөвлөлийг байгуулж байсан.Тус зөвлөлийн дарга Д.Должинсүрэн хувийн шалтгаанаар 2024 оны 11 сард ажлаас гарсан учир 2025 оны 01 сараас дахин шинэчлэгдэн байгуулагдсан.
Тус байгууллагын дэргэдэх ёс зүйн зөвлөлд:
Зөвлөлийн дарга: Ж.Отгонцэцэг / Төлөвлөлт хэрэгжилт хариуцсан сургалтын менежер /
Зөвлөлийн гишүүн: Д.Энхтуяа / Төлөвлөлт хэрэгжилт хариуцсан менежер /
Зөвлөлийн нарийн бичиг : П.Энхжаргал / Бичиг , хэрэг /

ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар

2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[2]:

- Байгууллагын багш ажилчдад " Хувь хүний ёс зүй " сэдэвт сургалтыг зохион байгуулсан.Сургалтаар хүний зан төлөв, үнэт зүйл, хариуцлага, зөв бурууг ялгах чадвар зэрэг асуудлыг хөндөж ажлын байранд өдөр тутамдаа ёс зүйтэй хандлагыг төлөвшүүлэх зорилготой явагдсан.
- 2025 онд шинээр монгол хэл, бичгийн багш Х.Баттөр шинээр ажилд орсон учир ёс зүйн хууль, журам, байгууллагын дотоод журмыг танилцуулж зөвшөөрлийн актад гарын үсгээ зурж баталгаажуулан ажилласан.
- Хувь хүний харилцаа сэдэвт чадавхжуулах сургалтад багш, ажилтануудыг хамруулсан.Сургалтыг сургалт судалгааны "Бодлого шийдэл төв"-ийн тэргүүн докторант А.Янжмаа, Удирдах зөвлөлийн гишүүн сэтгэл судлалын ухааны докторант Т.Нарангарав нар танин мэдэхүй, нийгэмшихүй, төлөвшихүй, хөгжихүй гэсэн бүлэг сэдвийн хүрээнд 8 нэгж сургалтыг зохион байгуулсан. Сургалтад нийт 22 хамрагдсан.
- Сэтгэлийн хөдөлгөөн, зан үйлээ хянах, зохицуулах нь сэдвүүдээр Гүн галуутай, Боловсрол сургуулийн 11-р ангийн 40 сурагчдад 8 цагийн сургалтыг зохион байгуулсан

2.2.Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:

Тус төвийн захирал А.Өсөхжаргал нь байгууллага хамт олноо ёс зүйгээрээ манлайлан ажилладаг. БЕГ болон дүүргийн засаг даргатай үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан ажилладаг бөгөөд улирал бүр дүгнүүлэхэд ямар нэгэн ёс зүйн зөрчил гаргаагүй.

- Хүний эрхийн активист, сургагч багш Б.Болороотой хамтран "Эрх мэдэлжүүлэх тухай", Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, НҮБ-ын конвенцийн тухай сургалтуудыг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчид, Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, дүүргийн бүх байгууллага, аж ахуй нэгжийн удирдлагуудад зохион байгуулсан.
- Дүүргийн Засаг даргын тамгын газар, Насан туршийн суралцахуйн төв хамтран иргэд, өсвөр үеийнхэнд Жендэрийн талаарх ойлголт өгөх, хэвшмэл ойлголт болон ялгаатай

[1] Байгууллагын харьяа салбар, нэгжийн хэмжээнд Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх байдлын талаар товч мэдээллийг тайлагнана.
[2] Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагааны талаар тайлагнана

байдлын талаар зөв мэдээлэл өгөх, цахим орчинд соёлтой байж шударга нийгмийг бий болгоход хувь нэмрээ оруулах зорилгоор " ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ" сэдэвт контент бүтээх уралдааныг нээлттэй зарлаж шилдэг контентийг шалгаруулсан. - **Дүүргийн ИТХ-ын ГХУСА33-өөс зохион байгуулсан " Авилга ашиг сонирхлоос ангид байх нь " соён гэгээрүүлэх сургалтад хамрагдсан.**
2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:
Зөвлөл байгуулагдаж 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг захирлаар батлуулж, дараах үйл ажиллагаануудыг төлөвлөсөн. Үүнд: - **Ёс зүйн хорооны төлөвлөгөө боловсруулан батлуулах** - Албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах - Шинээр ажилд орсон албан хаагчдад байгууллагад мөрдөгдөж буй дүрэм журмыг танилцуулж, мөрдүүлэх - **Албан хаагчдын сахилга, ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдлыг шийдвэрлэх** - **Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийг тогтмол** мэдээллийн самбар болон цахим хуудсанд байршуулах - Ёс зүйн дэд хорооны төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тайлагнах 2025 онд төлөвлөгөөний хэрэгжилтийг 100% ханган ажилласан.

Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл:
Ёс зүйн зөвлөлөөс зохион байгуулсан сургалтуудад хамрагдсанаар ёс зүйн хууль дүрэм журмуудтай танилцаж 2026 онд төлөвлөгөөндөө тусгах ажлуудаа төлөвлөсөн.	Ёс зүйн хууль эрх зүйн мэдээллүүдийг хаанаас илүү дэлгэрэнгүй авахыг мэдэхгүй байсан. 2025 оны төгсгөлд зохион байгуулагдсан сургалтаас илүү дэлгэрэнгүй мэдээлэл авсан.

Санал:
Цаашид " Ёс зүйн дэд хорооны гишүүдийг чадавхжуулах сургалт зохион байгуулвал хамрагдах, хөгжүүлэх сургалтуудад хамрагдах хүсэлтэй байна.

Шалгах хэсэг:

- ☐ "Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт"-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.
- ☐ **Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.**
- ☐ Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Томилох эрх бүхий албан тушаалтан

/Албан тушаал/ /Гарын үсэг/ /Гарын үсгийн тайлал/

Ёс зүйн дэд хорооны дарга

/Албан тушаал/ /Гарын үсэг/ /Гарын үсгийн тайлал/

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга

/Албан тушаал/ /Гарын үсэг/ /Гарын үсгийн тайлал/

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН НАСАН ТУРШИЙН СУРАЛЦАХУЙН ТӨВИЙН
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН 2025 ОНЫ ТАЙЛАН

НЭГ. Товч танилцуулга[1]

2025 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн захирлын А/43 дугаар тушаалаар 3 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй Ёс зүйн дэд хороог байгуулсан.
Ёс зүйн дэд хорооны дарга С.Будхүү (Хувь хүний хөгжил хариуцсан сургалтын менежер),
Гишүүн Н.Дашпил (Амьдрах ухааны ур чадвар хариуцсан сургалтын менежер),
Гишүүн Б.Урантуяа (Архив, бичиг хэргийн эрхлэгч)

ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар

2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[2]:

Үндэсний хөтөлбрийн хүрээнд:

- Ёс зүйн зөрчил болон санхүүгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх зөвлөмжийг албан хаагчдад өгч ажилласан.
- Төрийн албан хаагчийг албан тушаалд сонгон шалгаруулалт зарлан, сонгон шалгуулалтад тэнцсэн албан хаагчийг томилон ажиллуулсан.
- Санхүүгийн мэдээллийн самбарт мэдээллийг ил тод нээлттэй байршуулсан. Мөн Шилэн дансны цахим хуудсанд мэдээллээ хугацаанд нь байршуулан ажиллалаа.
- Төрийн албан хаагчдад Төрийн албан хаагчийн ёс зүй, Харилцааны ур чадвар, Авлигагүй нийгмийн төлөө бидний оролцоо сургалтуудыг зохион байгуулсан.

2.2.Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:

Томилох эрх бүхий албан тушаалтан нь Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, ёс зүйн хэм хэмжээг байгууллагын үйл ажиллагаанд төлөвшүүлэх чиглэлээр:

- ❖ Хувийн ашиг сонирхлын мэдүүлэгийг заагдсан хугацаанд удирдлага бөглөж, цахимаар баталгаажуулсан.
- ❖ Төрийн албаны сул орон тооны талаарх мэдээллийг байгууллагын пэйж хуудсаар нийт 7 удаагийн зар мэдээг оруулж, сонгон шалгаруулалтыг хийсэн.
- ❖ Байгууллагын санхүүжилт хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн талаарх мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг хангаж ажилтан албан хаагч нартаа тогтмол тайлагнан мэдээллэсэн.
- ❖ Байгууллагын удирдлагын зүгээс ёс зүйн дүрэм, холбогдох журам, зааврыг мөрдүүлэхэд анхаарч, албан хаагчдын ёс зүйн зөрчил гаргах эрсдэлийг бууруулах, сахилга хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.

2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:

- Байгууллагын цахим хуудсаар дамжуулан Ёс суртахуун, Авлигаас урьдчилан сэргийлэх агуулгаар 5 постер мэдээллийг бэлтгэн олон нийтэд түгээсэн.
- 2025 оны байдлаар Ёс зүйн зөрчил гарсан албан хаагч байхгүй. Албан хаагчдаас ёс зүйн өргөдөл, гомдол ирээгүй болно.
- Ёс зүйн асуудлаар албан хаагчдад зөвлөгөө, мэдээлэл өгсөн.
- Ёс зүйн дэд хороо нь улирал тутамд мэдээ мэдээллийг удирдлагад өгч ажилласан.

[1] Байгууллагын харьяа салбар, нэгжийн хэмжээнд Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх байдлын талаар товч мэдээллийг тайлагнана.

[1] Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагааны талаар тайлагнана.

Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл:
Баянзүрх дүүргийн Насан туршийн суралцахуйн төвийн Ёс зүйн дэд хороо нь батлагдсан төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа зохион байгуулж, дараах бодит үр дүнд хүрэв. Үүнд: Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, холбогдох дүрэм журмын хэрэгжилтийг хангах чиглэлээр сургалт, мэдээлэл, зөвлөмжийг тогтмол зохион байгуулж, албан хаагчдын ёс зүйн мэдлэг, хандлага, ухамсар дээшилсэн. Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал хангагдаж, ил тод, хариуцлагатай удирдлагын зарчим бодитой хэрэгжсэн. Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааны ил тод байдал, тайлагнал сайжирч, байгууллагын дотоод хяналтын тогтолцоо бэхжсэн.	Ёс зүйн зөрчлийн талаарх мэдээлэл, гомдол ирүүлэх идэвх сул, урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг бүрэн хэмжээнд үнэлэхэд хүндрэлтэй байсан. Насан туршийн суралцахуйн төвүүдэд ёс зүйн зөвлөмж зөвлөгөө өгөх мэргэжилтэн огт байхгүй тул ёс зүйн дэд хорооны групт элсэн орж мэдээллийг авч ажиллаж байв. Ажлын хэсэгт нэмэгдэл урамшуулал олгодоггүй.

Санал:

- Ёс зүйн хууль тогтоомж, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээрх сургалт, соён гэгээрүүлэх ажлыг Насан туршийн боловсролын салбарын удирдах алба, менежерүүд, багш нарын ажлын онцлогт нийцүүлэн төрөлжүүлж, цахим болон танхимын хосолсон хэлбэрээр тогтмол зохион байгуулах.
- Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг илүү үр нөлөөтэй болгох зорилгоор гишүүдийн чадавхыг бэхжүүлэх сургалт, туршлага солилцох уулзалтыг үе шаттайгаар зохион байгуулах.
- Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайллыг цаашид бэхжүүлж, үлгэр жишээ сайн туршлагыг байгууллагын хэмжээнд түгээн дэлгэрүүлэх.
- Бусад төрийн байгууллага, сургалтын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлж, ёс зүйн чиглэлээр нэгдсэн сургалт, хэлэлцүүлгийг тогтмол зохион байгуулах.
- Ёс зүйн дэд хорооны ажлын хэсэгт урамшуулал олгох төсвийг бүрдүүлэх.

Шалгах хэсэг:

- ☐ “Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт”-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.
- ☐ Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.
- ☑ Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Томилох эрх бүхий албан тушаалтан:
ЗАХИРАЛ _____ /Л.АТАР/

Ёс зүйн дэд хорооны дарга:
ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖИЛ ХАРИУЦСАН
СУРГАЛТЫН МЕНЕЖЕР _____ /С.БУДХҮҮ/

Ёс зүйн дэд хорооны гишүүн:
АРХИВ, БИЧИГ ХЭРГИЙН ЭРХЛЭГЧ _____ /Б.УРАНТУЯА/

Огноо: 2026 оны 01 сарын 02

Ёс зүйн хорооны 2025 оны 12 дугаар
сарын 01- ний өдрийн 09 дүгээр тогтоолын
гуравдугаар хавсралт

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

НЭГ. Товч танилцуулга
Баян-Өлгий аймаг дахь мэргэжлийн боловсролын сургуулийн Ёс зүйн дэд хороо нь тус сургуулийн захирлын 2024 оны 02-р сарын 14-ны өдөр А/07 дугаар тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан. Ёс зүйн дэд хорооны даргаар, Барилгын өргөн мэргэжлийн багш Х.Аманжол, нарийн бичгийн даргаар Хүний нөөцийн ажилтан Д.Адилбиш, гишүүдээр ХАБЭА, гамшгаас хамгаалах мэдлэг олгох мэргэжлийн багш Н.Ризагүл, компьютерын багш К.Еркин, Бизнес инкубатор төв хариуцсан ажилтан Х.Гүлмира нар сонгогдон ажиллаж байна. Ёс зүйн дэд хороо нь сургуулийн “Ёс зүйн дүрэм”-ийг 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр багш ажилтнуудын зөвлөгөөнөөр хэлэлцэн баталж, мөрдөн ажиллаж байна.
ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар
2.1. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт
Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр /2024-2030 он/-ийн зорилго зорилтыг хэрэгжүүлэх үүднээс дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд: 1. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг бууруулах үүднээс ёс зүйн чиглэлээр сургалт зохион байгуулж, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллалаа. 2. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, хариуцлагын бүртгэлийн хуудас нэвтрүүлж хэрэглэж эхэлсэн. Одоогоор ёс зүйн зөрчил бүртгэгдээгүй байна. 3. Сургуулийн сул орон тооны сонгон шалгаруулалт, албан тушаал дэвшүүлэх, шилжүүлэх, сэлгэн ажиллуулахдаа ёс зүйн нийтлэг шалгуурыг хангасан эсэхийг эн тэргүүнд харгалзан үзэх зарчмыг мөрдлөг болгон хүний нөөцийг бүрдүүлж байна. 4. Сонгон шалгаруулах ажлын хэсэгт ёс зүйн дэд хорооны төлөөллийг оруулан ажилладаг. 5. Тус сургуульд шинээр ажилд орсон багш ажилтнуудыг сургуулийн ёс зүйн дүрмийг таниулан сурталчлах сургалтад хамруулдаг. 6. Ёс зүйн чиглэлийн цахим сургалт, мэдээ мэдээллийг сургуулийн пейж хуудсаар дамжуулан багш, ажилтан, суралцагчид, олон нийтэд хүргэн ажилласан. 7. Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүдийг чадавхжуулах сургалтад хамруулах,

чиглүүлэх зөвлөгөө өгөх зэргээр ёс зүйн хорооны үйл ажиллагаанд дэмжлэг, туслалцаа үзүүлж, үйл ажиллагааг хичээлийн жилийн эцэст хамт олонд тайлагнаж ажиллаж байна. 8. Ёс зүйн гомдол, мэдээлэл, зөрчил, хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг "Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо" цахим системийн бүрэлдэхүүн болгон хөгжүүлж, үйл ажиллагаандаа тогтмол ашиглахаар ажиллаж байна. 9. Хүүхэд, залуучуудын шударга, зөв, ёс зүйтэй байх үзэл, хандлагыг төлөвшүүлэхэд чиглэсэн сэдэв, агуулга бүхий контентыг бүтээх, түгээх ажлыг хэрэгжүүлэхээр үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусгасан. 10. Сургуулийн орчин дахь ёс зүйн асуудал ба зөрчлийн талаарх олон нийтийн санаа бодлыг тандах судалгааг 2025 оны 12 дугаар сард багш ажилтнуудаас авч, судалгааг нэгтгэсэн бөгөөд судалгааны үр дүнг сургуулийн үр дүнг танилцуулах, арга хэмжээ зохион байгуулахаар ажиллаж байна.
2.2. Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал
Сургуулийн хэмжээнд ёс зүйн зөрчилгүй хамт олон болох үүднээс хуулийн байгууллагуудтай хамтарч гэмт хэрэг, зөрчил гарах шалтгаан нөхцөл, үр дагавар, хор хохирол, залилах, хулгайлах гэмт хэрэг, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн тухай болон Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хууль, Гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль, Авилга эсрэг хуулийг таниулан сурталчлах чиглэлээр 6 сургалт зохион байгуулсан бөгөөд багш ажилтнууд 100 хувь хамрагдсан болно. Сургалтуудыг үе шаттайгаар зохион байгуулснаар сургуулийн хэмжээнд гэмт хэрэг зөрчил гараагүй бөгөөд хуулийн хэрэгжилтийг бүрэн ханган ажиллалаа. Холбогдох дээд байгууллагаас гаргасан журам дүрэм, хууль тогтоомжийг тухай бүр пейж хуудас байршуулж, мөн нэгдсэн хурлаар дамжуулан багш, ажилтнуудад мэдээлж, таниулан сурталчлах ажлыг зохион байгуулан ажилладаг. Сургуулийн багш ажилтны нэгдсэн хурлыг 2025 онд 11 удаа зохион байгуулж, цаг үеийн мэдээ, мэдээллээр ханган ажилласан бөгөөд уг хуралдаанаар 21 асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн байна. БЯ, БЕГ-аас зохион байгуулсан “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын удирдах ажилтны сургалт зөвлөгөөн”, “Санхүүжилт ба түншлэл-2025” зэрэг танхимийн 2 сургалт, мөн 13 удаагийн онлайн сургалтад хамрагдаж, өөрийн мэдлэг, ур чадвараа дээшлүүлсэн бөгөөд сургалтын талаарх мэдээллийг тухай бүр сургуулийн багш ажилтнуудад мэдээлж ажилласан. Хууль, эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх 3 удаагийн онлайн сургалтад хамрагдсан.
2.3 Ёс зүйн хорооны үйл ажиллагаа
Тус сургуулийн ёс зүйн дэд хороо нь 2025 онд хийж хэрэгжүүлэх үйл ажиллагааны

төлөвлөгөөг боловсруулан сургуулийн захирлаар батлуулж, төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа зохион байгуулан ажиллаж байна. Ёс зүйн дэд хорооны гишүүдийг ёс зүйн чиглэлийн онлайн болон танхимийн сургалтад хамруулж чадавхжуулсан. Сургуулийн ёс зүйн дэд хороо нь “Ёс зүйн дэд хорооны дүрэм”-ийг шинэчлэн батлан мөрдлөг болгон ажиллалаа. Аймгийн Нийгмийн бодлогын хэлтэстэй хамтран Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр сургуулийн нийт багш ажилчдад 3 удаагийн сургалт зохион байгуулсан.

Гарсан үр дүн, амжилт:	Бэрхшээл:
Ёс зүйн зөрчил дутагдал илрээгүй бөгөөд байгууллагын соёл, дэг журмыг мөрдөн ажиллаж байна.	

Санал:

- Ёс зүйн дэд хорооны гишүүдийг сургалтад хамруулж чадавхжуулах

Шалгах хэсэг:

- “Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт”-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.
- Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.
- Байгууллагын 2025 оны ЁС зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

БАТАЛГААЖУУЛАЛТ:

ЗАХИРАЛ Х.РАУШАН

/Албан тушаал/ */Гарын үсэг/* */Гэрын үсгийн тайлал/*

Ёс зүйн дэд хорооны дарга Х.АМАНЖОЛ

/Албан тушаал/ */Гарын үсэг/* */Гарын үсгийн тайлал/*

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга Д.АДИЛБИШ

/Албан тушаал/ */Гарын үсэг/* */Гарын үсгийн тайлал/*

2025.12.30

Ес руйн хорооны 2020 оны 112 дугээр сарын
1-ний өдрийн 09 дугаар тогтоолын
Гуравдугаар хавсралт

БАЯНГОЛ ДҮҮРЭГ НАСАН ТУРШИЙН СУРАЛЦАХУЙН ТӨВИЙН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН "ТАЙЛАН

1.Товч танилцуулга

Баянгол дүүргийн Насан туршийн суралахуйн төв нь дүүргийн 262 000 хүн амд иргэний албан, албан бус сургалтаар боловсрол эзэмших, бие даан суралцахад мэдээллээр ханган, зөвлөн туслах, удирдан зохион байгуулах чиг үүргийг холбогдох хууль, тогтоомж шийдвэрийн дагуу орон нутагт хэрэгжүүлдэг. Үүнд:

- Бичиг үсгийн боловсрол
- ЕБС-ийн хичээл дүйцүүлэн боловсрол нөхөн олгох
- Гэр бүлийн боловсрол
- Хувь хүний хөгжлийн боловсрол
- Тогтвортой хөгжлийн боловсрол зэрэг боловсролын үйлчилгээг хууль тогтоомжид заасны дагуу танхимын сургалтад хамрагдах боломжгүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамжийн цогц үйлчилгээг эрх бүхий магадлан итгэмжлэгдсэн байгууллагатай хамтран зохион байгуулдаг.

Тус байгууллага 26 хүний бүтэц орон тоотой, ёс зүйн дэд хороо нь 3 хүний бүрэлдэхүүнтэй. Захирлын 2025 оны 09 сарын 10-ны өдрийн А/25 дугаар тушаалаар ёс зүйн дэд хороо байгуулж журам гарган ажилласан.

ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар

2.1. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт:

1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг удирдамж зааврааар хангаж, зохион байгуулалт 1 удаа хийсэн.

2. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг бууруулах замаар зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр. сургалт, нөлөөллийн 3 ажлыг төлөвлөж хороодын 150 гаруй иргэнийг хамруулсан.
3. Ёс зүйтэй ажиллах орчин, нөхцөлийг бүрдүүлэх албан хаагчийн үнэлгээ, урамшуулал, хариуцлагын тогтолцоотой уялдуулан хэрэгжүүлсэн. 2025 онд ёс зүйн талаар иргэдээс гаргасан өргөдөл, гомдолгүй ажилласан.

2.2. Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:

Төвийн захирлын эрхэлж буй ажил үүргийн хүрээнд ёс зүй, харилцаа, хандлагын зөрчилгүй ажилласан. Байгууллагын ажлын байрны сонгон шалгаруулалт, шилэн дансны мэдээлэл цаг хугацаандаа ил тод, нээлттэй явагддаг.

2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:

Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл:
Ёс зүйн дэд хороог журамд нийцүүлэн байгуулж, журам, төлөвлөгөөний дагуу ажилласан.	Байхгүй

Байгууллагад иргэдээс гаргасан гомдол зөрчилгүй ажилласан Байгууллагын 26 албан хаагчид “Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, хариуцлагын талаар 1 удаа сургалт явуулсан. Ёс зүйн дэд хорооны гишүүдэд ажлын үр дүнгээр улиралд 1 удаа 8 цаг хүртэлх урамшуулал илүү цагаар тооцон олгодог.	
Санал: байхгүй	

Шалгах хэсэг:

- "Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт"-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.
- Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.
- Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Томилох эрх бүхий албан тушаалта *Төвийн захирал* /Албан тушаал /	*Б.Гэрэлгуа* /Гарын үсэг/	..... /Гарын үсгийн тайлал/
Ёс зүйн дэд хорооны дарга Менежер /Албан тушаал/	Б.Баярсайхан /Гарын үсэг/	..... /Гарын үсгийн тайлал
Ёс зүйн дэд хорооны гишүүн Багш /Албан тушаал/	С.Соёл-Эрдэнэ /Гарын үсэг/	..... /Гарын үсгийн тайлал/

Огноо: 2025 оны 12. сарын 20

Ёс зүйн хорооны 2025 оны 12 дугээр
сарын 01-ний өдрийн 09 дугаар тогтоолын
гуравдугаар хавсралт

Булган аймгийн Насан туршийн суралцахуйн төвийн 2025 оны ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайлан

НЭГ. Товч танилцуулга	
Булган аймгийн Насан туршийн суралцахуйн төв аймгийн засаг даргын А/170-р захирамжаар 2017 оны 03 сарын 29-ны өдөр 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан. Одоо 7 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаагаа явуулж байна. Ёс зүйн дэд хороог 2025 оны 12 сарын 12-ны өдрийн захирлын А/20 дугаар тушаалаар байгуулсан. Дэд хорооны даргаар байгууллагын төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан сургалтын менежер Г.Сарантуяа, нарийн бичгийн даргаар албан бус боловсролын багш Н.Цэрэнлхам, гишүүнээр албан бус боловсролын багш Д.Ганцэцэг нар ажиллаж байна.	
Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар	
2.1. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3]:	
Үйл ажиллагааны төлөвлөгөө шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн батлахаар холбогдох дүрэм журам, тогтоол шийдвэрүүдийг судалж байна. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийгээгүй болно. Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгыг хүрээнд зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргахаар мэдээллийг бүрдүүлж байна. Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягтыг байгууллагын нийт албан хаагчдаар бөглүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна.	
2.2.Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:	
Гомдол санал ирээгүй байна. Гомдол санал ирээгүй тул төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулаагүй болно. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”-ын 3.8-д заасны дагуу шийдвэрлэхээр ажиллаж байна. Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг чанд мөрдөн, ёс зүйтэй, ил тод, шударга, харилцаа хандлагаар ажилтан албан хаагч нараа манлайлан ажиллаж байна.	
2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:	
Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэн дарга, нарийн бичиг, гишүүдээ томилоод байна. Одоогоор санал гомдол ирээгүй байна. Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт шийдвэрийг бүртгэж, тайлагнан ажиллана.	
Гарсан үр дүн, ололт амжилт	Бэрхшээл:
Ёс зүйн дэд хороог байгуулан цаашид хэрэгжүүлэн ажиллах үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахад шаардлагатай холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг уншиж судлан хэрэгжүүлэхээр ажиллаж байна.	Дэд хорооны гишүүдийн цалин урамшууллыг шийдвэрлэх төсөв, санхүүгийн боломж бага.
Санал:	

Шалгах хэсэг:

☐ “Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт”-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.

☐ Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.

☑ Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

БАТАЛГААЖУУЛАЛТ:

ТОМИЛОХ ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН

ЗАХИРАЛ /Т.ДЭЛГЭРМАА/

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДАРГА

БТХХ СУРГАЛТЫН МЕНЕЖЕР /Г.САРАНТУЯА/

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

НТСТӨВИЙН БАГШ /Н.ЦЭРЭНЛХАМ/

2026.01.02

Ёс зүйн хорооны 2025 оны ...125 дүгээр
сарын 01-ний өдрийн 09 дугаар тогтоолын
Гуравдугаар хавсралт

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН НАСАН ТУРШИЙН СУРАЛЦАХУЙН ТӨВИЙН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

НЭГ. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА
Төрийн албан хаагчийн ёсзүйн тухай хуулийн 10 дугаар зүйл, 10,4 дэх хэсэг , 11 дүгээр зүйлийн 11.6.7 дахь хэсэг 13 дугаар зүйл, Боловсрол Шинжлэх Ухааны сайдын 2022 оны 12-р сарын 20-ны өдрийн А/ 545 дугаар тушаал, тус төвийн хамт олны 04 дүгээр сарын 16-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн тус төвийн ёсзүйн дэд хороог Ёсзүйн хорооны дарга: Сургалтын менежер Р.Энхцолмон, Нарийн бичгийн дарга Иргэний боловсролын багш Н.Энхтүвшин, гишүүнээр нийгмийн ажилтан Х.Нандин-Эрдэнээр томилон ажиллуулсан.
ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар
2.1 Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт
Ёс зүйн хороо нь сар бүр албан хаагчид, ажилчдад ёс зүйн хэм хэмжээ, төрийн албан хаагчдын баримтлах ёс зүй, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах гэх мэт сургалт үйл ажиллагааг зохион байгуулж байна. Манай төвөөс төрийн байгууллагуудад байгууллагын соёл, хувь хүний соёл сэдвүүдээр сургалт тогтмол зохион байгуулан ажилладаг бөгөөд 10 гаруй байгууллагын 300 гаруй төрийн албан хаагчдад сургалт зохион байгуулсан байна.
2.2 Томилох эрх бүхий албан тушаалтны ёсзүйн манлайлал
Удирдах ажилтны ёс зүй хэм хэмжээг мөрдөн ямар нэг алдаа дутагдал зөрчил гаргалгүйгээр ажилладаг. Боловсролын ерөнхий хууль үндсэн хууль бусад холбогдох хууль тогтоомжуудыг судлан хэрэгжүүлэн биелүүлж багш ажилчдад сургалт үйл ажиллагааг зохион байгуулан зөвлөн тусалж ажилладаг. Төвийн багш нарт 7 хоног бүр, нэгжийн багш нарт сар бүр чиглэл өгч зөвлөн туслах ажлыг гүйцэтгэн тайлан мэдээг авч холбогдох байгууллгуудад цаг хугацаанд нь

хүргүүлэн ажилладаг. 2025 оныг “Хариуцлагатай хамт олон” уриалгыг дэвшлүүлэн төрийн албаны хариуцлагыг өндөржүүлэн ажлын байран дахь цаг ашиглалтыг үр бүтээлтэй болгох мэдээ мэдээлэл, сургалт, үйл ажиллагааг сар бүр дотооддоо зохион байгуулан ажиллаж байна. 2025-2026 оны хичээлийн жилд төрийн байгууллагуудаас ирүүлсэн сургалтын санал хүсэлтийг нэгтгэхэд ёс зүйн сургалт авах хэрэгцээ их байсан. Иймд Удирдлагын академиас зохион байгуулж буй "ёс зүйн сургагч багш" бэлтгэх сургалтын сонгон шалгаруулалтад материалаа хүргүүлээд байна. 2025 онд ёсзүйн алдаа зөрчилтэй холбоотой гомдол санал ирээгүй байна. Хөрөнгө орлогын мэдүүлгээ тогтоосон цаг хугацаанд нь мэдүүлэн ажиллаж байна.
2.3 Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:
Байгууллагын ёс зүйн дэд хороог шинэчлэн байгуулсан. Ёс зүйн дэд хороо нь Байгууллагын орчинд ёсзүйн зөв харилцаа, шударга ёс, нээлттэй, ил тод байдлыг төлөвшүүлэх, ёсзүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хяналт тавих, сахилга бат ёс суртахуунтай орчинг бүрдүүлэх зорилгын хүрээнд жилийн төлөвлөгөөг боловсруулан ажилласан. Ёсзүйн дэд хороо нь байгууллага хамт олонд эерэг хандлага түгээх олон шинэ ажлуудыг санаачилан зохион байгуулж байна. Үүнд: 1.Бие биедээ урам хайрлах талархалын 30 үгсийг хэлж хэвшүүлэх, 2.Байгууллагын соёл, сургалт, “Бид ёс зүйтэй хамт олон” нөлөөллийн ажил 3.Уриалга, зөвлөмжийг бэлтгэсэн. 4.Соёлын сарын хүрээнд бие биедээ өөрийн чаддаг зүйлсээ заах аяныг өрнүүлсэн. 5.Хамт олны дотоодын сургалт тогтмол зохион байгуулагддаг. 6.Төрийн албан хаагчийн ёс зүй, Алагчлаагүй оролцоог хангах сэтгэлгээ сэдвүүдээр аймгийн төрийн албан хаагчид, Алтай сум, Дарив, Цээл сумдын төрийн албан хаагчдад сургалт зохион байгуулан ажилласан. 7. Байгууллагын соёл сэдвээр төрийн байгууллагуудад сургалт зохион байгуулсан. Байгууллага дээр ёс зүйн алдаа гаргасан багш ажилчид удирдлага байхгүй байна.

Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл:
1. Ёс зүйн ойлголтын талаар суурь ойлголтыг өгч ажилчдын	1. Санхүүгийн бэрхшээл тулгарсан.

хэрэгцээнд тулгуурлан цаашид хийх ажлын төлөвлөгөө боловсруулсан. 2. Ёсзүйн дэд хороо байгуулагдсанаар байгууллага хамт олон дотор эерэг уур амьсгал бүрдүүлэх олон шинэ ажлуудыг санаачлан зохион байгуулсан.	2. Сургалт үйл ажиллагаа зохион байгуулахад дэд хорооны гишүүдийн мэдлэг мэдээлэл дутмаг байсан. 3. Чадавхжих сургалтад хамрагдах гэсэн боловч төлбөр өндөр байсан
Санал:	
1.Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг хэвийн явуулахад тодорхой хэмжээний төсөв санхүүг тавьж өгөх 2. Ёс зүйн дэд хороог чадавхжуулах цахим болон танхимын сургалтад хамруулах	

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Томилох эрх бүхий албан тушаалтан

....

Албан тушаал гарын үсэг гарын үсгийн тайлан

Ёс зүйн дэд хорооны дарга

Сургалтын менежер ..... /Р. Энхцэлмэг/

Албан тушаал гарын үсэг гарын үсгийн тайлан

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга

Цэцгийн багаварын багш ..... /Ц. Энхтуяа/

Албан тушаал гарын үсэг гарын үсгийн тайлан

Огноо: 2025 оны 12 сарын 30

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН НАСАН ТУРШИЙН СУРАЛЦАХУЙН ТӨВИЙН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2025.12.30

Нэг. Товч танилцуулга

Говьсүмбэр аймгийн Насан туршийн суралцахуйн төвийн захирлын 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А/03 дугаар тушаалаар "Ёс зүйн дэд хороо"-г 3 гишүүнтэй байгуулаж албан хаагчдын ёс зүй, ёс суртахууны боловсролыг дээшлүүлэн, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг зохион байгууллаа.

Ёс зүйн дэд хороо 2025 онд 4 агуулгын 9 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж, 91 хувийн гүйцэтгэлтэй байгаа бөгөөд 2025 онд ёс зүйн зөрчилгүй ажилласан.

Хоёр. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар

2.1 Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт:

2025 оны 04-р сарын 24-ний өдөр "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг нийт албан хаагчдад танилцуулж, мэдээлэл олгосон.

Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Авлигын эсрэг хууль, Захиргааны ерөнхий хуулийг тус тус үндэслэн "Байгууллагын ёс зүйн дүрэм"-ийн төслийг боловсруулан батлуулахаар албан хаагчид, удирдлагад танилцуулан санал авч хэлэлцүүлснээр 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн Б/13 дугаар тушаалаар "Ёс зүйн дүрэм"-ийг батлан хэрэгжүүлж байна. Ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд сар бүр үнэлгээ өгч, ур чадварын нэмэгдлийг олгож байна.

2.2 Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал

2025 оны 02 дугаар сарын 06-ны өдөр Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Монгол улсын гавьяат хуульч Б.Идэрчулуун **"Төрийн албан хаагчийн ёс зүй"** сургалтад хамрагдсан.

7:4:10" ЦАХИМ СУРГАЛТ, МЭДЭЭЛЛИЙН ЦАГ Төрийн албаны зөвлөлөөс тогтмол зохион байгуулдаг "7:4:10" цахим сургалт, мэдээллийн цаг 2025.11.13-нд Ёс зүйн хорооны Ажлын албаны дарга Н.Ганбаатар "Ёс зүйн төлөв байдал, эрсдэлийн үнэлгээний арга зүйн асуудал" сэдэвт сургалт мэдээлэлд ажилтан албан хаагчдаа 100 хувь хамруулсан.

Боловсролын сайдын "Байгууллагын соёл, багшийн ёс зүйн жил" зарлах тухай 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/30 дугаар тушаалын хэрэгжилтийн хүрээнд аймгийн Боловсролын газартай хамтарсан "Суралцагч-Боловсролын салбар" төлөвлөгөөг хэрэгжүүлсэн.

Тус төлөвлөгөөний дагуу 3, 4 дүгээр сард Монгол Улсын Төрийн албаны зөвлөлөөс зарласан "Төрийн албаны реформ-Бидний шийдэл" төрийн албан хаагчдын судалгаа, эрдэм шинжилгээний бүтээл шалгаруулах уралдаанд багш, албан хаагчдыг оролцуулан ажилласан. Уралдааны 2-р шатанд шалгарсан нэг албан хаагчийн бүтээлийг салбартаа болон төрийн албан хаагчдад цахимаар сурталчлан ажилласнаар 13000 иргэний хандалттай ажилласан.

2.3 Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа

2025 онд багш, ажилтнуудтай "Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг" гаргуулан албажуулсан. Дэд хорооны төлөвлөгөөний дагуу албан хаагчдад 4 удаагийн сургалт зохион байгуулж албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлсэн. Байгууллагын "Ёс зүйн дүрэм"-ийг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Хамт олны итгэлцлийг нэмэгдүүлэх, бусдын үнэт зүйл, зан төлөв, ажиллах хэв маягийг ойлгох зорилгоор "Case study discussion" арга хэмжээг зохион байгууллаа. Арга хэмжээний хүрээнд: Баг гэж юу вэ?, Би гэж хэн бэ? /сонсох үйл ажиллагаа/, Нүдээ боож алхах теамбилдинг арга хэмжээ, Сэтгэл ханамжийн судалгааг авч, албан хаагчдаа хамруулаа.











Гарсан үр дүн, ололт амжилт	Бэрхшээл
Байгууллагын дотоод дүрэм журамтай болсноор өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөх биеэ авч явах соёл, харилцаа, хандлага эерэг зөв болж байна.	-
Санал	
Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг хараат бус байдлаар шийдвэрлэдэг бүтцийг бий болгох, урамшуулал нэмэгдлийг тодорхой болгох	

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Томилох эрх бүхий албан тушаалтан

Захирал

/Албан тушаал/ /Гарын үсэг/ *Гарын үсгийн тайлал*

Ёс зүйн дэд хорооны дарга

/Албан тушаал/ /Гарын үсэг/ *Гарын үсгийн тайлал*

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга

Албан тушаал/ /Гарын үсэг/ *Гарын үсгийн тайлал*

Ёс зүйн хорооны 2025 оны 12 дугаар
сарын 01-ний өдрийн 09 дугаар тогтоолын
нэгдүгээр хавсралт

ATA11169 8448906
9023111371

БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ
"ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ"

№	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт		Авбал зохих оноо	Оноо[1]	Хувийн жин[2]
1	2	3		4	5	6
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3] (ҮХХ)	Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн батлалсан эсэх[4]		1	1	10
2		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх [5]		1		
3		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал	Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх [6]	0.5	0,5	5
			Соён, гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал[7]	0.5	0,5	5
			Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал[8]	0.5	0,5	5
			Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал[9]	0.5	—	—
		Хэсгийн оноо		4	2,5	25
4	Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн мэдлэйлал (ЁЗМ)	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх [10] *(гаргасан дүгнэлтийн хувийн жингээр тооцох бөгөөд гомдол ирээгүй бол 1 оноо)*		1	—	—
5		Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал[11]		1	—	—
6		Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал[12]		1	—	—
		Хэсгийн оноо		3	0	0
7	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа (ЁЗДХ)	Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал[13]		1	—	—
8		Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал [14] *(Гомдол ирээгүй бол 1 оноо вена. нийт ирүүлсэн өргөдөл, гомдлын хувийн жингээр тооцно)*		1	—	—
9		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж, тайлагнасан байдал [15]		1	—	—
		Хэсгийн оноо		3	0	0
		Үнэлгээний нийт оноо, хувь		10	2,5	25

$$\text{Эзлэх хувь} = \frac{\text{ҮХХ} + \text{ЁЗМ} + \text{ЁЗДХ}}{10} * 100\%$$

Тайлбар:

[1] Байгууллагын өөрийн болон харьяа, салбар байгууллагад өгсөн үнэлгээ

[2] Авсан оноог 10-аар үржиж хувийн жинг тооцох ба нийт дүн 100-с хэтрэхгүй байна

[3] УИХ-ын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлалсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"

[4] ЁЗХ-ны 2025 оны 04 дүгээр тогтоолоор батлалсан "Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт"-д нийцүүлэн батлалсан төлөвлөгөөг хавсарган ирүүлнэ.

[5] ЁЗХ-ны 2025 оны 06 дугаар "Аргачлал батлах тухай" тогтоол

[6] УИХ-ын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлалсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн 2.1 дэх хэсэг. ЁЗХ-ны 2024 оны 05 дугаар тогтоолоор батлалсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын 4.1.3. мөн оны 15 дугаар "Сургалтын агуулга, сэдэв батлах тухай" тогтоол

[7] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалт

[8] ЁЗХ-ны 2025 оны 06 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлалсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээний аргачлал"-ын 8.3.3. мөн оны 07 дугаар "Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргах, шалган шийдвэрлэх талаар авах арга хэмжээний тухай" тогтоол

[9]ЁЗХ-ны 2024 оны 13 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлалсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам"-ын 3.8 дахь хэсэг. 2025 оны 08 дугаар "Заавар батлах тухай" тогтоол

[10] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалт

[11] Мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг

[12] Мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалт

[13] ЁЗХ-ны 2024 оны 13 тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлалсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам"-ын 4.2.2 дахь заалт

[14] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.1 дэх заалт

[15] ЁЗХ-ны 2024 оны 13 тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлалсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам"-ын 4.4.3, 4.4.4 дэх заалт

-oOo-

ГОВЬСҮМБЭР ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

Нэг. Товч танилцуулга :

Говьсүмбэр аймаг дахь Политехник коллежийн дэргэдэх Ёс зүйн дэд хороо нь нийт хамт олны саналаар дэмжигдсэн 5 хүний бүрэлдэхүүнтэй 2024 оны 10 сарын 27-ны өдрийн захирлын тушаалаар байгуулагдан үйл ажиллагаагаа явуулан ажиллаж байна. Төрийн албан хаагчийн хууль тогтоомж, дүрэм, журам, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийг үндэслэн 2025 оны үйл ажиллгааны төлөвлөгөөгөө боловсруулан төлөвлөгөөний дагуу ажилласан.



Хоёр. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар

2.1. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт :

- 2025 оны төлөвлөгөөнд ёс зүйн зөрчил гаргахгүй эерэг уур амьсгалтай хамт олон байхын тулд хамт олны оролцоог нэмэгдүүлэх, нөлөөллийн ажлыг зохион байгуулах зорилгоор нийт багш ажилчдыг мэргэжлийн дагуу 16 багт хуваж 14 хоногт 1 удаа хамт олны дунд “**ЭЕРЭГ БҮХНИЙГ ТҮГЭЭЖ ЭНЕРГЭЭР ЦЭНЭГЛЭГДЭЭ**” уриатай уулзалт, арга хэмжээг зохион байгуулах хувиар гарган сургуулийн цахим группд байршуулсан. Хувиарын дагуу хариуцсан ёс зүйн дэд хорооны гишүүд багуудад сануулж арга хэмжээг хугацаанд нь хийж хувиарын дагуу амжилттай дараах ажлуудыг зохион байгуулсан.
  - II/1-15 хооронд эхний баг “**Зүгээр л магт**”
  - **II/15-28 хооронд “Инээд бэлэглэе ээ**”
  - III/**1-15**- ны хооронд **“Намайг таагаарай”**
  - III/**15-30**- ны хооронд **“ 60 секунд “**
  - IV/**1-15**- ны хооронд **“YES, NO**”
  - IV/**15-30**- ны хооронд **““Уян хатан байх нь эрүүл мэндийн үндэс юм**”
  - **V/1-15**- ны хооронд **“ Багийн ажиллагаа чухал**”

- **VI /1-15**- ны хооронд “ **Эх үрсийн баяр** ”
- **VI /15-30**- ны хооронд **“ Хамт олны аялал ”**
- **IX /1-15**- ны хооронд **“ Тогоруу, Торой, Тоорцог ”**
- **IX /15-30**- ны хооронд **“ Би хамгийн мундаг нь ”**
- **X /1-15**- ны хооронд **“ Та дараагийн хүндээ юу өгөх вэ ?”**
- **XI /1-15**- ны хооронд **“ Авхаалж самбаа “**
- **XII /1-15**- ны хооронд **“ Гарын 5 хуруу “**

- 2025 оны 1-р улиралд “**Инээмсэглэн угтаж талархуулан үдье**” аяныг хамт олны дунд зохион байгуулсан. Аян нь сургуулийн орчинд хараал хэлэх, чанга дуугаар хашгирах, хурал дээр утсаа унтраахгүй байх, ажлаас хоцрохгүй байх зэрэг хувь хүний соёлыг багасгах зорилгоор буруу үйлдэл гаргасан хүнд шийтгэлийн карт өгч аяны төгсгөлд дүгнэн шийтгэл авсан багш, ажилчдыг хөдөлмөрийн хэлбэрээр шийтгэж аян зохтон байгуулсан.
- 2025 оны 2-р улиралд **"АЗ ЖАРГАЛТАЙ АЖЛЫН 5 ХОНОГ"** аянг зарлаж хамт олны уур амьсгалыг сайжруулах үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан. Уриалгыг цаашдаа дагаж мөрдөж байх самбарыг УБ хотод хийлгэж гишүүд хувийн зардлаараа 200,000 төгрөг гаргасан. / Хүн бүр 40,000 төгрөг
  - **Даваа гариг – Улаан өнгө – Хайрлая, Халамжлья**
  - **Мягмар гариг – Улбар шар өнгө – Мэндэлье, Хүндэлье**
  - **Лхагва гариг – Шар өнгө- Инээмсэглэе, эерэг байе**
  - **Дүрэв гариг – Ногоон өнгө – Уучилья, Зөвлөлдье, Ойлголцьё**
  - **Баасан гариг – Цэнхэр өнгө – Эвлэлдэн нэгдье, Итгэж нөхөрлөе**
- 2025 оны 3-р улиралд Давуу талаа илрүүлж сул талаа засъя уриатай “ **НЭГ ӨДӨР НЭГ ТАНХИМ**” аяныг 30 хоногийн хугацаанд 24 анги танхим, 11 өрөө таслагаагаар аялуулж аян маань амжилттай дууслаа. Аянаар илэрсэн 28 давуу тал, 35 сул тал, 24 санал зөвлөмжийг нэгтгэн дүгнэж удирдлагын багш танилцуулан ажилласан.
- 2025 оны 4-р улиралд Политехник коллежийн Охидын өдөрлөгийн арга хэмжээнд Ёс зүйн дэд хороо хамтран нэг өртөө болон хамтран ажилласан. Сургалтаар ёс зүйн хорооны танилцуулга мэдээлэл болон охид ёс суртахууны ямар асуудлууд гаргадаг юм, түүнийгээ хэрхэн шийдвэрлэх талаар дасгал ажил хийлгэж охидын сургуульд нөлөөлөх нөлөөллийг оношилж илрүүлсэн. Мөн охид өөрийгөө хайрлах, харилцаа, хандлага болон биеэ зөв авч явах тал дээр зөвлөгөө мэдээллийг өгч ажилласан
- 2025 оны төлөвлөгөөний дагуу Ёс зүйн дэд хорооноос зохион байгуулсан "Ёс зүйн мэдлэгээ нэмэгдүүлье" уриатай “АЛТАН ХОНХ” уралдаан амжилттай зохион байгуулсан. Шагналын санг гишүүд өөрсдийн хөрөнгөөрөө санхүүжүүлсэн. Уралдаанд:
  - ✓ Захиргаа аж ахуйн албанаас тогооч Г.Цэрэндэлгэр Тэргүүн байр
  - ✓ Сургалтын албанаас Англи хэлний багш А.Чулуунчимэг Тэргүүн байранд орсон.
- Улсын Ёс зүйн хорооны “ **Хүндэлье ,Энэрье**” аяны хүрээнд хамт олны дундаас хагалгаанд орсон ажилтанд ёс зүйн дэд хорооноос санаачилан хандивын аян өрнүүлж 970,000 төгрөний цуглуулж эмчилгээнд нь хандивласан.

2.2. Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:

Томилох эрх бүхий албан тушаалтан нь хууль тогтоомжийн хүрээнд ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг тогтмол дэмжин санхүүжүүлж ирсэн. Ёс зүйн шийдвэр гаргалтаар байгууллагын соёлыг төлөвшүүлэх үйл ажиллагааг дэмжин ажилладаг.

2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:

- 2025 онд хийх ажлын төлөвлөгөөг дэд хорооны гишүүдийн бүрэлдэхүүнтай хамтран хууль, дүрэм, журам, үндэсний хөтөлбөртэй уялдуулан гаргаж батлуулсан.
- Политехник коллежийн удирдлага, багш, ажилтны ёс зүйн дүрмийг шинэчлэн боловсруулсан.Тус ажлын хүрээнд:
    - Дүрэм боловсруулахтай холбоотой хууль, дүрэм, журмуудыг дэд хорооны гишүүд цахим болон цаасаар судалсан.
    - дэд хорооны гишүүдээрээ ярилцаж дүрмээ боловсруулсан.
    - хамт олны цахим группд 2 хоногийн хугацаатай байршуулж санал авсан.
    - Ёс зүйн дүрмийг захирлын зөвлөлд танилцуулж эцэслээд хамт олны хурал дээр танилцуулан санал хурааж эцсийн байдлаар баталсан
    - Батлагдсан ёс зүйн дүрмийг брошурт хэлбэрээр боловсруулж хүн бүрт тарааж өгсөн.
    - Ёс зүйн дүрмийг хүлээн зөвшөөрч баталсан хүн бүрт Ёс зүйн дүрмийн **Батламж** гардуулан өгч гарын үсэг зуруулж ажилласан
- Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүд төлөвлөгөөт сургалт болох үйлчилгээний ажилчдад сургуулийн шинээр батлагдсан “Байгууллагын нийтлэг үйлчилгээний дүрэм” танилцуулах сургалт зохион байгуулсан. Сургалтыг 102 тоот кабинетад онолын мэдээлэл өгч, харуул, үйлчилгээний ажилчдад ажлын байран дээр нь дадлага ажил хэлбэрээр сургалтаа зохион байгуулсан.
- ГСА -ын Боловсролын газрын Ёс зүйн дэд хорооноос зохион байгуулсан 1 өдрийн сургалтанд Ёс зүйн дэд хорооны гишүүд ирц бүрэн хамрагдаж шинэ мэдээ, мэдээлэлтэй танилцсан.
- "Эмнэлэгийн мэргэжилтэний ёс зүйн зарчим" сэдэвт 2 багц цагийн төлбөртэй танхимын сургалтанд Аймгийн Нэгдсэн Эмнэлэгийн хурлын зааланд эмч Б.Алтанцэцэг хамрагдсан
- Төрийн албан хаагчийн ёс зүй, ёс зүйн дэд хорооны чиг үүрэг, ажиллах журам, хүний нөөцийн мэдээллийг бүртгэх нэгдсэн сан, өргөдөл гомдол шийдэрлэлтийн талаар мэдээлэл өгч хамт олонч эерэг байхыг уриалж сургалтыг зохион байгуулсан. Сургалтыг илүү хүртээмжтэй болгох үүднээс хамт олноо 3 хэсэгт хувааж 3 өдрийн сургалт, мэдээллийг чанартай хүргэж ажилласан.
    - Удирдлагын баг - IV/10 өдөр 15 цагт
    - Сургалтын албаны багш нар- IV/07 өдөр 16 цагт
    - ЗАААлбаны мэргэжилтэн, ажилчид -IV/07 өдөр 15 цагт
- Сургуулийн нийтлэг үйлчилгээний журмын талаар нэмэлт мэдээлэл өгөх сургалтыг харуулуудад зохион байгуулсан
- ПТКоллежийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлтэй хамтран эрчүүд, бүсгүйчүүдийн уламжлалт уулзалтыг зохион байгуулсан. Уулзалтыг 5-р сургуулийн сэтгэлзүйч, ХГХГазрын сэтгэлзүйч нартай хамтран зохион байгуулсан

- Шинээр ажилд орсон ажилтнуудад ёс зүйн дарга ёс зүйн хорооны гишүүд хууль, дүрэм, журам танилцуулсан. Нарийн бичиг ёс зүйн хорооны программ, өргөдөл гомдол шийдвэрлэх процессын талаар танилцуулсан.
- Төлөвлөгөөний дагуу 3-р улирлын багш, ажилчдад зорилусан сургалтаа Насан туршийн боловсролын газрын багш Даваажаргал “**Харилцаа, хандлага**” сэдвээрх сургатыг зохион байгуулсан.
- Боловсролын ёс зүйн хорооноос өгсөн үүргийн дагуу төрийн албаны зөвлөлөөс гаргадаг 7:4:10 мэдээллийн цагаар Ёс зүнй хорооны албанын дарга Ганбаатар ”**Ёс зүйн төлөв байдал, эрсдэлийн үнэлгээний аргазүйн асуудал**” сэвдээр цахим мэдээлэл өгсөн. Мэдээллийг гишүүд нэг тахимаас бөөндөө сууж авсан.
- Ёс зүйн дэд хороон дарга Ц.Мөнхцэцэг МУ-ын ёс зүйн хороо, удирдлгын академаас 2025 оны 11 сарын 17-20 хооронд зохион байгуулагдсан 32 цагийн сургагч багшийн сургалтанд хамрагдсан.
- 2025 онд ёс зүйн дэд хороонд 1 хүсэлт ирсэн. Хүсэлтийг үндэслэн гишүүд дараах ажлуудыг хугацаанд нь хийж гүйцэтгэсэн.
    - өргөдөлийн дагуу тайлбар авхаар П.Мөнхцоож, Д.Батсуурь, Цэрэндэлгэр, Гансүх нартай биечлэн уулзсан.
    - Ёс зүйн дэд хорооны гишүүд хуралдаж цаасаар болон биечлэн уулзсан тайлбаруудыг үндэслэн 1 дүгнэлт, 4 зөвлөмжүүдийг боловсруулан гаргаж баталгаажуулсан.
    - гаргасан 1 дүгнэлт, 4 зөвлөмжүүдийг холбогдох 1 хүнд цаасаар биечлэн өгсөн. Бусад 3 хүн нь ээлжийн амралттай байсан учир хувь чатаар нь илгээж утсаар ярьж мэдэгдсэн.
    - Захиралд гарсан дүгнэлт, зөвлөмжүүдийг танилцуулж 1% хуулбаруудыг өгч албаны менежерүүддээ хариуцсан доод албан тушаалын хүмүүсдээ аливаа зөрчил, гомдол, маргаан гаргахаас урьдчилан сэргийлэх ажлуудыг хийж байх талаар зөвлөмжийг хэлсэн.
- Говьсүмбэр аймгийн Боловсролын газрын ёс зүйн дэд хорооноос ирүүлсэн цахим судалгааг сургуулийнхаа цахим группд оруулан мэдээллэж багш, ажилчдаас цахим судалгааг авсан
- Сэтгэл ханамжийн судалгааг хагас, бүтэн жилээр цахим болон цаасаар авч нэгтгэн хамт олонд танилцуулан ажилласан.
- 2025-2026 оны хичээлийн жилийн эхний 14 хоногт дараах томоохон шалгалтуудад ёс зүйн дэд хорооны төлөвлөгөө, тайлан, мэдээг танилцуулж амжилттай хамгаалсан. Энэхүү шалгалтууд нь багагүй цаг орсон хариуцлагатай ажлууд байсан.

- Говьсүмбэр аймгийн архив бичиг хэргийн улсын үзлэгийн шалгалтанд бичиг баримтаа шалгуулсан.
- Боловсролын яамны мэргэжлийн хяналтын даргад бичиг баримтаа шалгуулсан
- Мэргэжлийн боловсролын байгууллагын ёс зүйн хорооны яаралтай судалгааг явуулсан.
- ГСА-ын боловсролын газарт ёс зүйн хорооны судалгааг өгсөн

- Монгол улсын Төрийн албаны зөвлөлийн ХНУМТ цахим системд бүртгүүлэн Ёс зүйн зөрчил, бүртгэл, хяналтын модулийн нэвтрэх мэдээлэллэлтэй танилцаж ёс зүйн дэд хорооны гишүүдийн мэдээлийг нэмж бүртгүүлсэн
- ГСА-ын Боловсролын газраас ирүүлсэн маягтын дагуу хугацаанд нь судалгааг гарган боловсролын газрын цахим чат болон сургуулийн нарийн бичигт файлаар илгээсэн
- Ёс зүйн дэд хороон дарга Ц.Мөнхцэцэг ёс зүйн дэд хорооны ажиллах 2024 оны 2 сарын 19-ны өдрийн 05 тогтоолын дагуу гишүүдэд урамшуулал олгох тушаалын санал боловсруулж батлуулсан.
- Ёс зүйн дэд хорооны гишүүдийн ирц бүртгэл, үйл ажиллагаа сургалт, семинарын ирц, ирсэн, хүлээлгэн өгсөн баримтын нотолгоог багтаасан ирц бүртгэлийн дэвтэр гарган ашиглаж байна. Тус дэвтэрийн бүртгэлээр оны төгсгөлд тухайн жилийн хугацаанд хэдэн удаа, хэдэн сургалт үйл ажиллагаанд хамрагдаж байсныг нотлох зорилготой баримт бичиг юм
- **“Байгууллагын соёл, багшийн ёс зүйн жил”** болгон зарласантай холбогдуулан байгууллагын соёл, өнгө үзэмжийн эхлэл нь багш, ажилчдын дүрэмт хувцас учир дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.Тус ажлын хүрээнд:
  - Хамт олонд дүрэмт хувцас хэрэгтэй юу? гэсэн асуулгын хүрээнд хамт олноос цаасаар санал авсан. Саналаа нэгтгэхэд 90% нь хэрэгтэй гэсэн дүгнэлт гарсан учир дүрэмт хувцасны судалгааг хийсэн.
  - Үнэ, загварын судалгаа хийсэн.
  - Хар зураг гарган удирдлагуудад танилцуулж нэмэлт саналуудыг тусган эцсийн байдлаарх ЗААА, СА-ны эрэгтэй, эмэгтэй багш ажилчдын дүрэмт хувцасны загварыг гаргасан.
  - Оёдолын олон газарт судалгаа хийсны үндсэн дээр аймаг орон нутгийнхаа бизнес эрхлэгч “**Бүрэн урлан**” ХХК-ыг сонгон 1 ажлын цамцыг 70,000 төгрөгөөр хийхээр болж тохиролцсон. Нийт багш, ажилчдад санхүүгийн ачаалал үүсгэхгүй байх зорилгоор ажил олгогч 30,0 төгрөг, Үйлдвэрчний эвлэл 20,000 төгрөг гаргаж хувиасаа 20,000 төгрөг гаргаж хийсэн.
  - Энэхүү хувцас нь сургуулийн үндсэн өнгө болох логоны өнгөөр хийлгэсэн. Сургалтын алба нь дээгүүрээ улбар шар, доогууруа хөх өнгөтэй, захиргаа аж ахуйн ажилчид дээгүүрээ хөх доогууруа улбар өнгөтэй байхаар хийлгэсэн. Мөн энэ хувцасыг зөвхөн энэ 4 өнгөөр бүх багш ажилчдад хийлгэсэн нь харуул үйлчлэгч гэж хүнийг албан тушаалаар ялгаварлахгүйгээр жендерийн мэдрэмжттэй хийсэн болно
  - Ажлын дүрэмт хувцасыг 2,4 өдрүүдэд өмсөж хэвших уриалга гаргаж ажилласан

- IV/7-ны өдрийн сургалтын завсарлагаанаар 2025 оны 03 сарын 3 ны өдрийн ГСА-ын Боловсролын газрын даргын тушаалыг танилцуулсан. Тус тушаалд:
    - Ажил үүргээ гүйцэтгэсний төлөө шан харамж авахгүй байх
    - Эцэг эхийн зөвлөл санаачилсан нэрээр баяр хийж, аялалхгүй байх
    - Ёс зүйн хороо урьдчилан сэргийлэх сургалт хийх
    - Эрдэм оюун ухаанд суурилсан баяр зохион байгуулах гэсэн утга бүхий албан тоотыг танилцуулсан
- Ёс зүйн дэд хорооны танилцуулга, тушаал, шийдвэр, санал хүсэлт, мэдээ, мэдээлэл зэргийг багш, ажилчид болон иргэдэд танилцуулах мэдээллийн самбарын загвар гарган захиалга өгсөн.
- Ёс зүйн дэд хороонд санал хүсэлтээ цахимаар бичих боломжийг ханган ажиллахын тулд GMAII хаяг нээж санал, хүсэлтээ илгээж ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн. /**ptk.ethics.2025@gmail.com** /
- Ёс зүйн дэд хорооноос 2025 онд зохион байгуулсан үйл ажиллагаа бүрийн ирцийн дэвтэр дээр гарын үсэг зуруулан бүртгэж авдаг. Оны төгсгөлд ирцийг нэгтгэн тухайн жилийн шилдэг ёс зүйтэй ажилтан шалгаруулах уралдааны 1 шалгуур болон оруулж ажилладаг.
- Сар бүр ажлын тайлан бичиж сургуулийн захиргаагаар үнэлүүлж ажиллсан. 2025 оны төлөвлөгөөны 93% гүйцэтгэлтэй сайн ажилласан гэж дүгнэж байна.

Гарсан үр дүн, ололт амжилт:	**Бэрхшээл:**
Байгууллагын соёлын хүрээнд шинэ дүрэмт хувцас хийлгэснээр хувцасаа өмсөх өдөртэй болж хэвшин байгуллагын өнгө үзэмж дээшилсэн. Угтах үйлчилгээний харилцаа хандлага сайжирсан Шинээр ажилд орсон багш ажилтнуудад хууль, дүрэм, журмын мэдээлэл өгснөөр илүү хурдан байгууллагадаа дасан зохицож ёс зүйг эрхэмлэдэг болсон. Хамт олны оролцоонд тулгуурласан үйл ажиллагаа явуулсанаар хамт олны уур амьсгал сайжирсан.	Ёс зүйн дэд хорооны гишүүдийн бусад үндсэн ажлын ачаалал их Төр, хувийн хэвшлийн үйл ажиллагаа давхардах Гишүүдийн урамшуулал тогтмол олгохгүй байх

Санал:

Ёс зүйн дэд хорооны гишүүдийн урамшууллын сар бүр олгох
Аймаг, орон нутгийн мэдээлэл солилцох, тайлан мэдээ өгөх, авах, үнэлэх газар нь тодорхой бус
Хяналт шалгалтууд урьдчилан мэдэгдэж удирдамжтай ирдэггүй гэнэтийн шалгалтууд их ирдэг нь ажлын ачаалал үүсгэж үл ойлголцох нөхцөл болдог

Шалгах хэсэг:

Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ хийсэн эсэх,

Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд хийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх

Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Томилох эрх бүхий албан тушаалтан

Захирлын үүрэгт хавсран гүйцэтгэгч

/Албан тушаал/ /Гарын үсэг/ /Гарын үсгийн тайлал/

Ёс зүйн дэд хорооны дарга

/Албан тушаал/ /Гарын үсэг/ /Гарын үсгийн тайлал/

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга

/Албан тушаал/ /Гарын үсэг/ /Гарын үсгийн тайлал/

Огноо: ..... оны .... дугаар сарын ...-ны өдөр.

БАТЛАВ.
ЗАХИРАЛ Ш.ОТГОНЖАРГАЛ

2025.01.1

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хийгдэх ажил	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Хугацаа	Хариуцах эзэн
		1. Хүний нөөцийн хүрээнд			
1	Байгууллагын багш ажилчидын ёс зүйн дүрэм журмыг боловсруулан батлуулах	- Байгууллагын ёс зүйн дүрмийг хэлэлцэх	Байгууллагын ёс зүйн дүрэмтэй болсон байна.	1 сар	Ёс зүйн дэд хороо
2	Шинээр томилогдсон албан хаагчид ёс зүйн дүрмийг танилцуулах	- Шинээр томилогдсон албан хаагчийн тоо - Хэрэгжилт	Шинээр томилогдсон албан хаагч ажлын байранд төрийн албанд мөрдөгдөх хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг судласан байна.	Жилдээ	Хүний нөөц, Ёс зүйн дэд хороо
3	Байгууллага болон багш ажилчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд “Байгууллагын багш ажилчдын ёс зүй дүрэм журам”-ыг хэрэгжилтийг хангуулах талаар заалт тусгах	- Албан хаагчдын төлөвлөгөөнд тусгагдсан заалт	Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан заалтын хэрэгжилт 100 хувь	Жилдээ	Ёс зүйн дэд хороо
4	Байгууллагын багш ажилчдыг дүрэмт хувцсаар жигдрүүлэх	- Ажлын байрны дүрэмт хувцастай өдөрт хувцсаа өмсөж хэвшүүлэх /7 хоногийн 1,3,5 өдрүүдэд/	- Ажлын байрны дүрэмт хувцастай өдөрт хувцсаа өмсөж хэвшсэн байна./7 хоногийн 1,3,5 өдрүүдэд/	Жилдээ	Ёс дэд хороо, ХАБ, Ажил олгогч

2. Гомдол мэдээллийн, ёс зүйн зөрчлийн судалгаа, тайлан, дүн шинжилгээний чиглэлээр					
5	Албан хаагчдын ёс зүйн зөрчил гаргасан тухай гомдол, мэдээллийг хүлээн авч үндэслэлийг шалган тогтоож дүгнэлт гаргах	- Гаргасан гомдлын тоо - Шийдвэрлэсэн дүгнэлтийн тоо - Хариуцлага оногдуулсан албан хаагчийн тоо	Гүйцэтгэлээр	Тухай бүр	Ёс зүйн дэд хороо
6	Багш, ажилчид, оюутан суралцагчдаас ёс зүй харилцаа хандлагын сэтгэл ханамжийн судалгаа авах, дүгнэлт гаргах	- Судалгааны асуулга боловсруулах - Судалгаанд хамрагдсан албан хаагч оюутны тоо		Улиралд 1 удаа	Ёс зүйн дэд хороо
3. Сургалт, соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны чиглэлээр					
8	Төрийн болон төрийн бус байгууллагаас зохион байгуулж буй сургалтад албан хаагчдыг хамруулах	- Сургалтын тоо - Хамрагдсан албан хаагч	- Сургалтанд бүрэн хамрагдсан байна.	Жилдээ	Ёс зүйн дэд хороо
9	Харуул болон үйлчилгээний ажилчдад үгтах үйлчилгээ, харилцаа хандлагын сургалт зохион байгуулах	- Ажлын байрны тодорхойлтын дагуу ажил үүргээ биелүүлэх - Бүртгэлийн дэвтэр гаргуулах	- Байгууллагын дүрэм журмыг дагаж мөрдөх - Харилцаа хандлагыг сайжруулах - Үйлчилгээний соёлыг түгээн дэлгэрүүлэх	1 сар	Ёс зүйн дэд хороо
10	Байгууллагын багш ажилчдын, ёс зүйн Дүрэм журмыг танилцуулах, батламж гардуулах/АХА, Дэвжээ, Алтан хонх/	- Танилцуулсан байдал - Батламжийн хэрэгжилт	- Ёс зүйн зөрчил гараагүй байна. - Гарын авлага тараасан байна.	2 сар	Ёс зүйн дэд хороо
11	Эвсэг хамт олон найрсаг харилцааг бүрдүүлэх ёс зүйн уриалга гаргах	- Мэндлэх - Талархах - Уучлалт хүсэх - Инээмсэглэх	- Хамт олны уур амьсгал сайжирсан байна.	Сар бүр	Ёс зүйн дэд хороо Бүх багш ажилчид

		- Зөвшилцөх - Хүндлэх - Магтах урамшуулах - Туслах			
12	"Эерэг бүхнийг түгээж энергээр цэнэглэгдэе" уулзалт	- Уулзалт зохион байгуулагдсан байна. - Уулзалтын дүрэмтэй байна.	- Хамт олны уур амьсгал сайжирсан байна.	Сард 2 удаа	Ёс зүйн дэд хороо Бүх багш ажилчид
13	Багш ажилчдад ёс зүйн нөлөөллийн сургалтыг зохион байгуулах	- Жилд 4 сургалт	- Жилд 4 сургалт зохион байгуулсан байна.	Жилдээ	Ёс зүйн дэд хороо Бүх багш ажилчид
		4. Бусад			
14	Зөрчлийн цахим бүртгэл, мэдээллийн цахим самбарыг ажиллуулах, ёс зүйн зөвлөлийн төлөвлөгөө, тайланг олон нийтэд мэдээлэх, сурталчилах	- Ёс зүйн зөрчлийн цахим бүртгэл хөтлөсөн байдал - Цахим самбар байршуулсан мэдээллийн тоо	- Шилдэг ёс зүйтэй ажилтан шалгарсан байна. - Цахим бүртгэлийн системтэй болно.	Сар бүр	Ёс зүйн дэд хороо
15	Ёс зүйн дэд хорооны ажлын тайланг танилцуулж, ёс зүйн зөрчлийн мэдээг аймгийн Төрийн албаны зөвлөлийн Говьсүмбэр аймаг дахь салбар зөвлөлд хүргүүлэх	- Мэдээ тайлангийн тоо: 5 сарын 20, 11 сарын 15	Мэдээ тайлан хугацаандаа чанартай гарсан байна.	5 сарын 20, 11 сарын 15	Ёс зүйн дэд хороо

Төлөвлөгөө боловсруулсан: Ёс зүйн дэд хороо

ПТК дэргэдэх Ёс зүйн дэд хорооны 2025 оны хийж гүйцэтгэсэн ажлын хураангүй тайлан

2025.12.01.

№	Агуулга	Тоо хэмжээ	Он сар өдөр	Үйл ажиллагаа	Хамрах хүрээ	Хамрагдалт	Үр дүн
1	**Төлөвлөгөө**	1	1 сард	2025 онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулах	Ёс зүйн дэд хороо	1	2025 онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлагдсан.
2	**Дүрэм, журам**	1	1,2 сард	2025 оны ёс зүйн дүрэм шинэчлэн боловсруулах	Бүх багш, ажилчид	1	Удирдлага, багш, ажилчны ёс зүйн дүрэм шинэчлэн боловсруулагдсан. Бүх хүнд Батламж гардуулан ажилласан.
3	**Өргөдөл гомдол**	1	2 сард	ЗАААлбаны менежерээс ирсэн өргөдөл	Харуул, тогооч	4	Өргөдөлийн дагуу 3 удаа хуралдаж холбогдох хүмүүсээс бичгээр болон бичелэн мэдүүлэг авч протокол хөтөлсөн. Мэдүүлэг, нотлох баримтыг үндэслэн зөрчил биш гэж дүгнэсэн учир холбогдох 4 хүнд зөвлөмж хүргүүлэн ажилласан.
4		1	2 сард	Байгууллагын нийтлэг үйлчилгээний дүрэм танилцуулах сургалт орох	Үйлчилгээний ажилчид	20	"Байгууллагын нийтлэг үйлчилгээний дүрэм"ыг танилцуулан биечлэн дадлага ажил хэлбэрээр сургалтыг зохион багйуулсан.

5		2	2 сард	Ёс зүйн дэд хорооны ажиллах журам	Ёс зүйн дэд хорооны гишүүд	5	Боловсролын газраас зохион байгуулсан ёс зүйн дэд хорооны гишүүдийн чадавхижуулах сургалтанд хамрагдсан.
6		3	2 сард	Эмнэлэгийн мэргэжилтэний ёс зүйн зарчим	эмч	1	ГСА-ын Нэгдсэн эмнэлэгийн хурлын зааланд эмч сургалтанд хамрагдсан.
7		4	4 сард	Төрийн албан хаагчийн ёс зүй, ёс зүйн хорооны чиг үүрэг, ажиллах журам, өргөдөл гомдолын талаарх сургалт	Удирдлагын баг	7	Ёс зүйн дэд хорооны гишүүд Төрийн албан хаагчийн ёс зүй, ёс зүйн хорооны чиг үүрэг, ажиллах журам, өргөдөл гомдол талаарх сургалтыг кейс дээр тулгуурлан ажиллуулж зохион байгуулсан.
8		5	4 сард		Багш нар	35	Ёс зүйн дэд хорооны гишүүд Төрийн албан хаагчийн ёс зүй, ёс зүйн хорооны чиг үүрэг, ажиллах журам, өргөдөл гомдол талаарх сургалтыг кейс дээр тулгуурлан ажиллуулж зохион байгуулсан.
9		6	4 сард		ЗААА албаны мэргэжилтэн, ажилчид	16	Ёс зүйн дэд хорооны гишүүд Төрийн албан хаагчийн ёс зүй, ёс зүйн хорооны чиг үүрэг, ажиллах журам, өргөдөл гомдол талаарх сургалтыг кейс дээр тулгуурлан ажиллуулж зохион байгуулсан.
10		7	5 сард	Харуулийн сургалт	Харуул, сантехникч, жижүүр	8	Нийтлэг үйлчилгээний журам, ёс зүйн хорооны нэмэлт мэдээлэл өгсөн
11	**Сургалт /14/**	8	5 сард	Эрчүүдийн сургалт	Эрэгтэй багш, ажилчид	20	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлтэй хамтран ГБХГазрын сэтгэлзүйчтэй хамтран сургалтыг эрчүүдэд зохион байгуулсан.

12		9	5 сард	Эмэгтэйчүүдийн сургалт	Эмэгтэй багш, ажилчид	33	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлтэй хамтран 5-р сургуулийн сэтгэлзүйчтэй хамтран сургалтыг эмэгтэйчүүдэд зохион байгуулсан.
13		10	9 сард	Шинэ ажилтны сургалт	Шинэ ажилтан	3	Шинээр ажилд орсон хүмүүсд төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулт, ПТК-ын ёс зүйн дүрмийг танилцуулж батламж гардуулсан.
14		11	10 сард	Харилцаа хандлага	Бүх багш ажилчид	38	ГСА-ын Насан туршийн боловсролын төвийн багш Даваажаргал хамт олонд чиглэсэн " Бие хүний хандлага ба оршихуй" сэдвээр сургалт орсон.
15		12	11 сард	Ёс зүйн хорооны цахим сургалт	Ёс зүйн дэд хорооны гишүүд	4	Боловсролын ёс зүйн хорооноос өгсөн үүрэг даалгаварын дагуу Ёс зүйн хорооны албаны дарга Ганбаатарын " Ёс зүйн төлөв, байдал, эрсдэлийн үнэлгээний аргазүйн асуудал" сэдэвт цахим сургалтанд хамрагдсан.
16		13	11 сард	Залуу багш нарын сургалт	Залуу багш нар	4	2025 ондоо ажилд орсон залуу багш нарт ёс зүйн чиг үүрэг, хуулийн заалтууд болон ёс зүйн дүрмийн сургалт зохион байгуулсан.
17		14	10 сард	Ёс зүйн сургагч багш	Ёс зүйн дэд хороон дарга	1	МУын ёс зүйн хороо, Удирдлагын академи хатран зохион байгуулсан сертификаттай сургалтанд хамрагдсан.
18		15	12 сард	Шинэ ажилтны сургалт	Ёс зүйн дэд хороон дарга	6	Шинээр ажилд орсон хүмүүсд төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулт, ПТК-ын ёс зүйн дүрмийг танилцуулж батламж гардуулсан.

19	**Нөлөөллийн арга хэмжээ /14/**	1	2 сард	"**Эерэг бүхнийг түгээж энергиэр цэнэглэгдэе**" уриатай хамт олны оролцоон дээр тулгуурласан нөлөөллийн ажлыг зохион байгуулах, Бүх багш, ажилчдыг багт хувааж сард 2 багын үйл ажиллагаа зохион байгуулах	Бүх багш, ажилчид	77	1-р баг " **Зүгээр л магт**" талархлын арга хэмжээг зохион байгуулсан.
20		2	2 сард		Бүх багш, ажилчид	39	2-р баг " **Инээд бэлэглэе ээ**" арга хэмжээг зохион байгуулсан.
21		3	3 сард		Бүх багш, ажилчид	32	3-р баг " **Намайг таагаарай**" арга хэмжээг зохион байгуулсан.
22		4	3 сард		Бүх багш, ажилчид	44	4-р баг " **60 секунд**" арга хэмжээг зохион байгуулсан.
23		5	4 сард		Бүх багш, ажилчид	42	5-р баг " **Уян хатан байх нь эрүүл мэндийн үндэс юм**"" арга хэмжээг зохион байгуулсан.
24		6	5 сард		Бүх багш, ажилчид	28	6-р баг " **YES or NO**" арга хэмжээг зохион байгуулсан.
25		7	5 сард		Бүх багш, ажилчид	26	7-р баг " **Багийн ажиллагаа чухал**" арга хэмжээг зохион байгуулсан.
26		8	6 сард		Бүх багш, ажилчид	78	9-р баг " **Эх үрсийн баяр** "-ын арга хэмжээг зохион байгуулсан.
27		9	6 сард		Бүх багш, ажилчид	38	10-р баг " **Хамт олны аялал**" -ын арга хэмжээг зохион байгуулсан.
28		10	9 сард		Бүх багш, ажилчид	37	11-р баг " **Тогоруу, Торой, Тоорцог**" арга хэмжээг зохион байгуулсан.
29		11	9 сард		Бүх багш, ажилчид	27	12-р баг " **Би хамгийн мундаг нь** " -ын арга хэмжээг зохион байгуулсан.
30		12	10 сард		Бүх багш, ажилчид	70	13-р баг " **Та дараагийн хүндээ юу өгөх вэ** " видео чэлленж арга хэмжээг зохион байгуулсан.

31		13	11 сард сард		Бүх багш, ажилчид	23	14-р баг " **Авхаалж, самбаа** " арга хэмжээг зохион байгуулсан.
32		14	12 сард		Бүх багш, ажилчид	38	15-р баг " **Гарын 5 хуруу** " арга хэмжээг зохион байгуулсан.
33		15	11 сард	Залуу багш нарын нөлөөллийн ажлууд	Бүх багш, ажилчид	4	"**Зөв багш, Сайн үлгэрлэл**" аяны хүрээнд 4 залуу багш нараар нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулсан.
34	**Уриалга,**	1	2 сард	Хамт олны уур амьсгалыг сайжруулах, стрессыг бууруулах ажлын хүрээнд уриалга гарган ажиллах	Бүх багш, ажилчид	63	" **Инээмсэглэн угтаж талархуулан үдье"** аяныг зохион байгуулсан. Аяны хүрээнд сургуулийн орчинд хараал хэлэх, чанга дуугаар хашгирах, хурал дээр утсаа дуугаргах, ажлаас хоцрох, дүрэмт хувцасаа өмсөх, уурлах зэрэг хувь хүний соёлын буруу үйлдэлыг багасгах зорилгоор алдаа гаргасан хүнд шийтгэлийн карт өгсөн. Картан дээрх шийтгэл нь хөдөлмөрөөр гүйцэтгэх шийтгэлүүд байсан ба уг ажил нь маш их үр дүнтэй ажил болж өрнөсөн.
35		2	5 сар		Бүх багш, ажилчид	78	"**Аз жаргалтай ажлын 5 хоног**" аян зарлаж гариг бүрийг уриа үг, нэг өнгийн хувцас өмсөж уриалга гаргаж ажилласан. / Даваа гариг - Улаан өнгө-Хайрлая, Халамжлъя, Мягмар гариг-Улбар шар-Мэндэлье, Хүндэлье, Лхагва гариг-Шар өнгө-Инээмсэглэе, Эерэг байе, Пүрэв гариг-Ногоон-Уучилъя, зөвлөлдье, ойлголцьё, Баасан-цэнхэр-Эвлэлдэн нэгдье, итгэж нөхөрлье/ Ёс зүйн дэд хороон гишүүд өөрийн санхүүжилтээр уриалгын хүрээнд ханын самбар гаргаж байршуулсан.

36	**Нөлөөллийн ажил /4/**	3	9		Бүх багш, ажилтан, оюутнууд	560	Давуу талаа илрүүлж сул талаа засъя уриатай" **НЭГ ӨДӨР НЭГ ТАНХИМ**" аяныг 30 хоногийн хугацаанд аялуулж манай сургуулийн давуу болон сул талыг тодорхойлуулж нэгтгэн 2 албаны менежерт бичгээр өгч танилцуулсан.
37		4	12	АЛТАН ХОНХ ХУУЛИЙН ТЭМЦЭЭН	Бүх багш, ажилчид	33	2025 оны төлөвлөгөөний дагуу Ёс зүйн дэд хорооноос зохион байгуулсан "Ёс зүйн мэдлэгээ нэмэгдүүлье" уриатай “АЛТАН ХОНХ” уралдаан амжилттай зохион байгуулсан.
		5	12	Хүндэлье, Энэрье аян	Бүх багш, ажилчид	58	Улсын ёс зүйн хорооны Хүндэлье, энэрье аяны хүрээнд хагалгаанд орсон ажилтанд хандивын аян өрнүүлж 970.000 төгрөгийг эмчилгээний зардалд нь өгсөн.
38		6	12	Охидын өдөрлөг	Сургуулийн эмэгтэй оюутнууд	42	Ёс зүйн дэд хорооны чиг үүрэг, ёс суртахуунтай холбоотой биеэ авч явах соёл, харилцаа, хандлага сэдвүүдээр уулзалт ярилцагыг хамтран зохион байгуулсан.
39	**Сэтгэл**	1	6 сард	Эхний хагас жилийн сэтгэл ханамжийн судалгаа	Бүх багш, ажилчид	45	Сэтгэлийн ханамжийн судалгааг авя нэгтгэн тайлагнасан.

40	**ханамжийн судалгаа /2/**	2	12 сард	Сүүлийн хагас жилийн сэтгэл ханамжийн судалгаа	Бүх багш, ажилчид	51	Сэтгэлийн ханамжийн судалгааг авя нэгтгэн тайлагнасан.
41	**Судалгаа /4/**	1	2 сард	ГСА -ын Боловсролын газраас авсан судалгааг өгөх	Ёс зүйн дэд хорооны гишүүд	5	Ёс зүйн дэд хорооны гишүүдийн судалгааг Боловсролын газарт цахимаар гаргаж өгсөн.
42		2	2 сард	Дүрэмт хувцасны судалгаа авах	Бүх багш, ажилчид	56	3 асуулгаар судалгааг цассаар авч нэгтгэхэд хэрэгтэй гэсэн судалгаа гарсан.
43		3	3 сард	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай судалгаа	Бүх багш, ажилчид	30	ГСА-ын Боловсролын газраас цахимаар авсан судалгаанд хамруулсан.
44		1	1 сард	Ирцийн бүртгэл хөтлөх	Бүх багш, ажилчид	29	Ирцийн бүртгэлийг тухай бүр бүртгэх дэвтэр гарган хөтөлж ирцийг нэгтгэн гаргасан.
45		2	3 сард	Дүрэмт хувцас шинэчлэх	Бүх багш, ажилчид	70	Монгол улсын Боловсролын сайдын 2025 оны 01 сарын 27-ны өдрийн А/30 тоот тушаалаар "Байгууллагын соёл, багшийн ёс зүйн жил" болгон зарласантай холбогдуулан багш, ажилтны дүрэмт ажлын цамцыг ажил олгогч, үйлдвэрчний эвлэл, хамт олонтойгоо хамтран шинэлэн хийсэн.
46		3	4 сард	Тушаал танилцуулах	Багш нарт	45	2024 оны 3 сарын 3-ны өдрийн ГСА-ын Боловсролын газрын даргын тушаалыг багш нарт танилцуулсан.

47	**Бичиг баримт, бусад ажлууд /7/**	4	4 сард	Санал хүсэлт хүлээн авах	Бүх багш, ажилчид	0	Санал хүсэлт хүлээн авах хайрцаг болон цахимаар авах gmail хаяг нээн багш, аижлчид санал, хүсэлтээ чөлөөтэй илэрхийлэх боломж олгож ажилласан.
48		5	5,12 сард	Ирцийн мэдээ	Бүх багш, ажилчид	2	Ёс зүйн хорооноос зохион байгуулсан сургалт, семинар, хурал, уулзалт, нөлөөллийн ажилд хамрагдсан ирцийг нэгтгэн QR болгон нийтэд танилцуулсан.
49		6	1-12 сарын хооронд	Боловсруулсан бичиг баримт	Сургуулийн эмэгтэй оюутнууд	29	Дүгнэлт 1, Мэдүүлгийн протокол 9, хурлын тэмдэглэл 4, албан тоот 6, зөвлөмж 8
50		7	1-12 сарын хооронд	Тайлан	ЁЗДХороо	29	10 удаагын тайланг ПТК захиргаанд улирал , хагас, бүтэн жилийн тайланг ГСА боловсролын газарт цахимаар илгээсэн.
Нийт давхардсан тоо						**2035**	Давхардсан тоогоор 2035 багш, ажилтанд сургалт нөлөөллийг ажлуудыг хийсэн.

Тайлан нэгтгэн бичсэн

Ёс зүйн дэд хорооны нарийн бичиг М.Чулуунцэцэг

2025.12.01.

Ёс зүйн хорооны 2025 оны 12 дугаар
сарын 01-ний өдрийн 09 дүгээр тогтоолын
гуравдугаар хавсралт

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН НАСАН ТУРШИЙН СУРАЛЦАХУЙН ТӨВИЙН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

2025

НЭГ. Товч танилцуулга
Насан туршийн суралцахуйн төвийн захирлын 2025 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн А/22 тушаалаар байгууллагын ёс зүйн зөвлөлийг 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр батлсан. Дарга: Хувь хүний хөгжил хариуцсан сургалтын менежер О.Чимэдцэрэн Гишүүд: Цахим ур чадвар хариуцсан сургалтын менежер Ю.Мөнхзаяа Архив бичиг хэргийн эрхлэгч, зохион байгуулагч Д.Оюунтунгалаг
ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар
2.1 Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт:
Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолын хавсралт Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр /2024-2030 он/ -ийг албан хаагчдад танилцуулж гарын үсэг зуруулж баталгаажуулсан. Мөн ТАХ-ийн ёс зүйн тухай хуулийн сургалт зохион байгуулахад 15 албан хаагч хамрагдсан. “Ёс зүйтэй багш” freme-д албан хаагчдын зургийг оруулж олон нийтэд сурталчилсан.
2.2 Томилох эрх бүхий албан тушаалын ёс зүйн манлайлал:
- Шинээр ажилд орох албан хаагчдад көүч /чиглүүлэгч/ томилж өгч байгууллагын дотоод дүрэм, журам, соёлтой танилцуулах ажлыг хийж хэвшүүлсэн. - Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэхдээ хамт олны дундаас ажлын хэсэг гаргаж нээлттэйгээр тайлан тавиулж үнэлж ур чадварын нэмэгдэл олгодог. - Төрийн албан хаагчдыг шагнаж урамшуулахад хамт олны хурал зохион байгуулж Сумын засаг даргын жуух бичгээр 3, аймгийн засаг даргын жуух бичгээр 1, аймгийн тэргүүний ажилтан цол тэмдгээр 1, Найрамдлын дархан тэмдгээр 1, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор 1 албан хаагчийг шагнаж урамшуулсан.

2.3 Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:	
Насан туршийн суралцахуйн төвийн захирлын 2025 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн А/22 тушаалаар байгууллагын ёс зүйн зөвлөлийг 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр батлсан. Ёс зүйн дэд хороо Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, ТАХ-ийн ёс зүй харилцаа сэдэвт сургалт 2 удаа, Эрүүл зөв дадал хэвшүүлэх 21 хоногийн аян зохион байгуулж ажлын байрны дасгалыг хэвшүүлж хөдөлгөөний дутагдлаас сэргийлсэн. Байгууллага хамт олны уур амьсгалыг сайжруулах нөлөөллийн ажлыг 3 удаагийн тэмдэглэлт баяр ёслолын арга хэмжээнд тусгаж хэрэгжүүлсэн. Ёс зүй, харилцаа сэдэвт 5 хичээлийг бэлтгэж 250 иргэнийг хамруулсан.	
Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл:
ТАХ-дын дунд зөрчлийн агуулгатай өргөдөл гомдол гараагүй болно.	
Санал	
Ёс зүйтэй холбогдолтой олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагаа зохион байгуулахад төсөв, санхүү байдаггүй тул бүх байгууллагын төсөвт сургалтын зардал, шатахууны зардал хуваарилж олгох	

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Томилох эрх бүхий албан тушаалтан

Заместител /Албан тушаал/ тайлал/ _____ /Гарын үсэг/ Н. Хасбаатарын /Гарын үсгийн

Ёс зүйн дэд хорооны дарга

ахлах /Албан тушаал/ тайлал/ _____ /Гарын үсэг/ О. Чимэгмаа /Гарын үсгийн

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга

Үүрэх менежер /Албан тушаал/ тайлал/ Ю.Монхзаяа /Гарын үсэг/ Ю.Монхзаяа /Гарын үсгийн

Огноо: 2025 оны 12 сарын 30 .

-2025 оны 10 дугаар сарын 15-16-ний өдрүүдэд Мерит Консалтинг Сервис ХХК-тай хамтран нийт багш, ажилтнуудад зориулсан хууль эрх зүй, харилцаа хандлага, баг хамт олны удирдлага, манлайллын чиглэлээр мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, ажлын гүйцэтгэлийг сайжруулах зорилгоор сургалт зохион байгуулсан.	
Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл:
-Суралцагчдын ёс зүйн зөрчил өмнөх жилийнхтэй харьцуулахад 20%-иар буурсан. -Багш, ажилтны хариуцлага сахилга бат сайжирсан. -Ёс зүйн хяналт хийгдэж сургалтын орчинд эерэг хандлага өөрчлөлт гарсан.	-Ёс зүйн хорооны гишүүдийн ажлын ачаалал их, үүрэгт ажлыг бүрэн хийж гүйцэтгэх зав багатай. -Ёс зүйн асуудлыг үнэн зөв, шударгаар үнэлэх мэдлэг, туршлага дутмаг -Зарим гишүүдийн оролцоо сул идэвхгүй
Санал:	
-Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг тогтмол идэвхтэй явуулах -Багш, ажилтан, суралцагчдад ёс зүйн сургалт, хэлэлцүүлэг, аян зохион байгуулах -Ёс зүйн мэдлэг, хандлагыг дээшлүүлэх, аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх -Мэдээллийн нэгдсэн систем, цахим бүртгэлтэй болох -Хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх -Гишүүдийн идэвх оролцоог нэмэгдүүлэх, ажлын цагийн ачааллыг тэнцвэртэй болгох	

Шалгах хэсэг:

- ☐ “Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт”-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.
- ☐ Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.
- ☐ Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Томилох эрх бүхий албан тушаалтан
ЗАХИРАЛ Б.НАРАНТУЯА

Ёс зүйн дэд хорооны дарга
СУРГАЛТЫН МЕНЕЖЕР Л.ЭНХМАА

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга
БАГШ Б.ӨНӨРЦЭЦЭГ

Огноо: ..... оны ..... сарын .....

Ёс зүйн хорооны
2025 оны ... дүгээр сарын ...-ний өдрийн
... дугаар тогтоолын гуравдугаар хавсралт

БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

НЭГ. Товч танилцуулга[1]
Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилтийг ханган Дархан Политехник коллежийн Ёс зүйн дэд хороог захирлын 2024 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн А/ 39 тоот тушаалаар 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Дархан Политехник коллежийн Ёс зүйн дэд хороо нь 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, багш, ажилтан, суралцагчтай холбоотой ёс зүйн асуудлыг хянан хэлэлцэж гаргасан шийдвэр, дүгнэлт авсан арга хэмжээ болон үр дүнг нэгтгэн дүгнэсэн. Багш, ажилтны ёс зүйн зарчим, нийтлэг хэм хэмжээг сахиулах, ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүйн хэм хэмжээг чандлан биелүүлэх, байгууллагын үнэт зүйл, соёлыг төлөвшүүлэх, зөрчлийг хянан шийдвэрлэх, шударга, хариуцлагатай, ёс зүйтэй орчныг төлөвшүүлэхэд чиглэсэн санал, зөвлөмж боловсруулан ажилласан.
ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар
Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[2]:
-Ёс зүйн зөвлөл нь батлагдсан төлөвлөгөөний дагуу 6 удаа хуралдаж асуудлыг шийдвэрлэсэн. -Багш, ажилтан, суралцагчтай холбоотой 2 асуудлыг хэлэлцсэн. -1 багшид сануулах арга хэмжээ авах зөвлөмж дүгнэлтийг захиргааны зөвлөлд санал оруулж сануулах арга хэмжээ авсан. -Алба нэгжүүдэд шударга хариуцлагатай, ёс зүйтэй орчныг төлөвшүүлэхэд чиглэсэн санал зөвлөмж дүгнэлтийг хүргүүлсэн.
2.2.Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:
Дархан-Уул аймгийн Дархан Политехник коллежийн захирлын тушаалаар томилогдсон Ёс зүйн дэд хорооны дарга нь хорооны үйл ажиллагааг шударга ил тод хариуцлагатай удирдсан. Ёс зүйн хороогоор хэлэлцсэн ёс зүйн асуудлыг ил тод баримт нотолгоотой, шударгаар шийдвэрлэж, хорооны гишүүд багш, ажилтнуудад эерэг аюулгүй таатай орчин бүрдүүлэх, ёс зүйн соёлыг төлөвшүүлэх, ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангах, сахилга хариуцлагыг дээшлүүлэхэд эерэг нөлөө үзүүлж ажилласан байна.
2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:
-Ёс зүйн дэд хорооны 2025-2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан баталгаажуулж хэрэгжилтийг ханган ажиллалаа. -Ёс зүйн хорооны дүрэм, журам баримт бичгийг шинэчлэн боловсруулллаа. -Ёс зүйн зөрчлийн талаарх мэдээ мэдээлэл, санал гомдлыг хүлээн авах бүртгэх -Ёс зүйн Академийн сургалтанд байгууллагаараа хамрагдаж 2025 оны “Байгууллагын соёл ба ажилтнуудын ёс зүй “ сэдэвт анхан шатны сургалтанд хамрагдаж 0169 дугаартай гэрчилгээтэй болсон.

